



ҮЕ ТЭНГИЙН ДАРАМТ, ДЭЭРЭЛХЭЛТЭЭС УРЬДЧИЛАН СЭРГИЙЛЭХ АРГАЧЛАЛ

Гарын авлага



УИГАН
СУДАЛГААНЫ САГ



“Бүх нийт боловсролын төлөө!”
Иргэний нийгмийн үндэсний эвсэл

ҮЕ ТЭНГИЙН ДАРАМТ, ДЭЭРЭЛХЭЛТЭЭС УРЬДЧИЛАН СЭРГИЙЛЭХ АРГАЧЛАЛ Гарын авлага

(Багш, сурган хүмүүжүүлэгч, эцэг эх асран хамгаалагчдад зориулав)

UIH.MN
СУДАЛГААНЫ САН

Улаанбаатар хот
2020 он

ҮЕ ТЭНГИЙН ДАРАМТ, ДЭЭРЭЛХЭЛТЭЭС УРЬДЧИЛАН СЭРГИЙЛЭХ АРГАЧЛАЛ

Боловсруулсан:

Б.Батчимэг
Ц.Одончимэг
Ц.Ононтуул
Б.Хулан

Хянасан:

Я.Мөнхчимэг
Д.Тунгалаг

Дизайнер: Ж.Халиунцэцэг
Цаасны хэмжээ: А4
Хэвлэлийн хуудас: 6,5 х.х



БИТ ПРЕСС ХХК-д хэвлэв.
Утас (976) 11 311322

UIH.MN
СУДАЛГААНЫ САН

БОЛОВСРОЛЫН ТӨЛӨӨ ЧАНГА ДУУГАРЦГААЯ!
төслийн санхүүжилтээр хэвлэв.

ГАРЧИГ

Өмнөх үг	4
Үндэслэл.....	5
Гарын авлагын зорилго, хүрэх үр дүн	5

Нэгдүгээр бүлэг. Үе тэнгийн дээрэлхэлт, түүний уршиг

Нөхцөл байдлын судалгаа.....	6
Ялгаатай байдлыг хүндэтгэж, хүний эрхийн хандлагыг төлөвшүүлэх нь	9
Үе тэнгийн дээрэлхэлтийн эсрэг авч хэрэгжүүлэх арга хэмжээний үе шатууд.....	11

Хоёрдугаар бүлэг. Үе тэнгийн дарамт, дээрэлхэлтийг зогсоох сургуулийн орчин дахь манлайлал

Дээрэлхэлтээс урьдчилан сэргийлэх арга зам	12
1. Сургуулийн эерэг уур амьсгал, хүчирхийллийг үл тэвчих соёл буюу эерэг хандлага төлөвшүүлэх нь	12
2. Үр дүнтэй манлайлал	14
3. Дээрэлхэлт болон түүний хор уршгийн талаарх нэгдсэн ойлголт	15
4. Дээрэлхэлтийн эсрэг журам буюу дээрэлхэлтийн зан үйлийг устгах механизм	16
5. Урьдчилан сэргийлэх, ойлголт нэмэгдүүлэх стратеги	18
6. Дээрэлхэлтийг таслан зогсоох стратеги	20
7. Нотолгоонд суурилсан хариу арга хэмжээний тактикууд	22

Гуравдугаар бүлэг. Сургуулийн орчинд хэрэгжүүлж болох практик үйл ажиллагааны чиглэл

1. Сургууль дээрээ кампанит ажил зохион байгуулах 5 алхам.....	25
2. Сургуулийн орчинд зохион байгуулж болох идэвхтэй үйл ажиллагааны санаанууд.....	27
3. Багш нар юу хийж чадах вэ?	30
4. Гэр бүл, асран хамгаалагчдыг татан оролцуулах нь	31
5. Сурагчид хамгийн чухал оролцогчид	35
6. Тэгш хамруулах боловсролын сайн туршлагаас суралцъя	36
7. Нэмэлт: Анхаарах нэгэн зүйл	42

Хэрэглэгдэхүүн

Хавсралт 1.....	44
Хавсралт 2	45
Хавсралт 3	46
Нэмэлт мэдээлэл 1.....	47
Нэмэлт мэдээлэл 2	48
Нэр томъёоны тайлбар	49
Ашигласан эх сурвалж	51

“Бүх нийт боловсролын төлөө!” Иргэний нийгмийн үндэсний эвслийн тунхаг	52
--	----

ӨМНӨХ ҮГ

“Бүх нийт боловсролын төлөө!” Иргэний нийгмийн үндэсний эвсэл боловсролын орчин дахь (дотуур байрыг оролцуулан) хүүхэд хамгааллын механизмыг бүрдүүлэх, үйл ажиллагаанд оруулах чиглэлээр 2018 оноос эхлэн бодлогын нөлөөлөл хийж байна. Өсвөр үеийн хүүхдүүдийн дунд судалгаа хийхэд ялгаварлан гадуурхалт болон үе тэнгийнхний дарамт, дээрэлхэлтэд өртөх нь нэмэгдэж байгаа нь бидний анхаарлыг татсан юм. Мөн түүнчлэн боловсролын бодлогоос ихэвчлэн хаягддаг дотуур байрны хүүхэд хамгааллын асуудлыг хөндөж байна.

ЕБС-ийн 6-18 насны 35,196 хүүхэд жилийн 224-245 хоногийн хугацаанд буюу 9 сар эцэг эх, гэр бүлээс хол 517 дотуур байранд амьдарч, боловсрол эзэмшиж байна. Дотуур байранд хүүхдийн эрүүл, аюулгүй, хүчирхийлэлгүй орчин бүрдээгүй хүүхдийн хамгаалагдах эрх хангагдахгүй байгааг удаа дараа хийсэн судалгааны дүн нотолж байгаа ба хамгийн сүүлд хийгдсэн судалгаа нийт дотуур байрны 76.2%-д хүүхдүүдийн дунд бие биенээ дээрэлхэх явдал их, бага ямар нэг хэмжээгээр байгааг харуулжээ.

Сургууль, дотуур байр, цэцэрлэгийн орчны аюулгүй байдал, үл ялгаварлан гадуурхах, хүчирхийлэл, үе тэнгийн дарамтаас урьдчилан сэргийлэх, хүүхэд хамгааллын чиглэлээр ахиц дэвшил гарч, багшийн ёс зүйн дүрмийг шинэчлэн батлах зэргээр хүүхдийг амжилттай сурахад ээлтэй сургалтын орчин бүрдүүлэх чиглэлээр бодлогын шийдвэрүүд гарч хэрэгжиж эхэллээ.

Гэхдээ эдгээр бодлого, дүрэм, журмыг сургууль дээр хэрэгжүүлэхэд сургуулийн хамт олонд бэрхшээл тулгарч байна. Түүний нэг нь хүүхдийн эрх, хамгааллын талаарх мэдлэг ойлголт дутагдах, арга аргачлал байхгүй байх явдал гэдгийг манай гишүүн байгууллагуудын хийсэн 2018 оны мониторингийн дүн харуулсан юм.

Сургуулийн хүүхэд хамгааллын бодлого болон Боловсролын сургалтын орчин ба дотуур байранд хүүхэд хүчирхийлэлд өртөхөөс сэргийлэх журамд заасан үе тэнгийн дарамт, дээрэлхэлийг зогсоох, урьдчилан сэргийлэх чиглэлээр сургууль дээр үйл ажиллагаа зохион байгуулахыг заасан байдаг. Тиймээс Боловсрол эвслийн гишүүд өөрсдийн мэдлэг, туршлагад суурилан энэхүү хэрэгжүүлж болохуйц санаагаар дүүрэн аргачлал, гарын авлагыг боловсруулсан билээ.

Сургууль дээрх хүчирхийлэл, ялангуяа үе тэнгийн дарамт дээрэлхэлт нь сурлагын амжилт, хүүхдийн хүүхдийн эрүүл мэнд, сайн сайхан байдалд сөрөг нөлөөтэй тул сургуулийн хамт олны оролцоотой хэрэгжих үйл ажиллагаануудыг багш, гэр бүлийн гишүүд, суралцагч гэсэн 3 оролцогч талд зориулан тодорхойлсон. Сургуульд зориулсан аргачлалыг боловсруулах турших үйл ажиллагаанд манлайлан оролцсон гишүүн байгууллагуудад, тухайлбал “Боловсролын Зөвлөгөө мэдээллийн төв” ТББ, “ЛГБТ төв” ТББ, “Хөөрхөн зүрх” ТББ-ын ажилтнуудад талархаж байгаагаа илэрхийлж байна.

“Бүх нийт боловсролын төлөө!” Иргэний нийгмийн үндэсний эвслийн

Ерөнхий зохицуулагч Д.Тунгалаг

ҮНДЭСЛЭЛ

“Бүх нийт боловсролын төлөө!” Иргэний нийгмийн үндэсний эвсэл нь сурч боловсрох эрхийн хэрэгжилт, түүнд саад тотгор болж буй нийгэм, эдийн засаг, соёлын хүчин зүйлсийг тодорхойлж, бодлогын нөлөөлөл хийх зорилгоор үе тэнгийн дарамт, дээрэлхэлт хүчирхийллийн асуудалд анхаарал хандуулсан билээ. Манай улсын боловсрол сургалтын байгууллагад бугшсан энэ сөрөг соёл Үндсэн хуулийн оршил хэсэгт байдаг хүмүүнлэг, иргэний, ардчилсан нийгэм бүтээх зарчим, зорилгыг бүдгэрүүлсээр байна. Учир нь ялгаатай байдлыг хүлээн зөвшөөрөх, хүний эрхэм чанарыг хүндэтгэх хүний эрхийн соёл боловсролын байгууллагад төлөвшөөгүй цагт бид хүмүүнлэг нийгмийг бүтээх боломжгүй юм. Тиймээс Боловсрол эвслийн гишүүд хамтран энэхүү гарын авлагыг бүтээж, сургуулийн удирдлага, багш сурган хүмүүжүүлэгчид, эцэг эх, асран хамгаалагчид болон бүх шатны боловсролын байгууллагын суралцагчдад хандан үе тэнгийн дарамт дээрэлхэлтийг боловсролын орчинд (дотуур байрыг оролцуулан) халж, хүний эрхэд ээлтэй орчин, соёл, хандлагыг нийгэмд тогтооход хувь нэмрээ оруулахыг уриалж байна.

“ҮЕ ТЭНГИЙН ДЭЭРЭЛХЭЛТЭЭС УРЬДЧИЛАН СЭРГИЙЛЭХ УДИРДАМЖ” ГАРЫН АВЛАГЫН ЗОРИЛГО

Сургуулийн орчинд үйлдэгдэж буй жендэрт суурилсан хүчирхийлэл, үе тэнгийнхний дарамт, дээрэлхэлтийн талаарх олон нийтийн ойлголт, хандлагыг нэмэгдүүлж, сургууль дээр эерэг уур амьсгалын өөрчлөлт гаргах

ЗОРИЛТ

- Сургуулийн удирдлага, багш, сурагч, эцэг эх, асран хамгаалагчид үе тэнгийн дарамт дээрэлхэлтийн талаарх ойлголтоо нэмэгдүүлэх
- Сургуулиа үе тэнгийн дээрэлхэлтгүй орчин болоход нь хувь нэмрээ оруулах хамтын оролцоотой аян зохион байгуулах
- Сургуулийнхаа орчинд үе тэнгийн дарамт, дээрэлхэлтээс урьдчилан сэргийлэх механизм хөгжүүлэх

ХҮРЭХ ҮР ДҮН

- Сургуулийн материаллаг бус таатай орчин буюу дарамт, хүчирхийлэлгүй орчин бүрдсэнээр суралцагчдын сурлагын амжилт дээшлэх нэг хүчин зүйл болно.
- Суралцагчдын хөгжил төлөвшилд эерэг нөлөө, үр дүн гарна.
- Сургуулийн орчин хүүхдэд ээлтэй аюулгүй болсноор нийгэмд жендэрт суурилсан хүчирхийлэл, ялгаварлан гадуурхалт буурахад нөлөө үзүүлнэ.

Үе тэнгийн дээрэлхэлт, түүний уршиг



НӨХЦӨЛ БАЙДЛЫН СУДАЛГАА

Хүний эрхийн Үндэсний Комисс 2017 оны Монгол улс дахь хүний эрх, эрх чөлөөний байдлын талаарх ээлжит илтгэлээрээ хүүхдийн эрхийн хэрэгжилтийн зарим асуудлыг судалгааны үндсэн дээр хөндсөн байдаг. Монгол улс дахь хүүхдийн эрхийн хамгийн нийтлэг зөрчил нь хүүхдийн эсрэг хүчирхийлэл¹, түүний нэг хэлбэр болох үл хайхрах явдал хэмээн дээрх судалгааны үр дүнгээс харагддаг. Уг судалгааг Улаанбаатар хотын 7 дүүрэг, 8 аймгийн нутаг дэвсгэрт амьдарч буй 12-18 насны нийт 4264 хүүхэд, 2743 эцэг эх, асран хамгаалагч, хүүхэд хамгааллын хамтарсан багийн 152 гишүүнийг хамруулсан бөгөөд асуулгад оролцсон нийт хүүхдийн² 17,2 хувь нь ямар нэгэн хүчирхийлэлд өртөж байгаагүй гэсэн бол үлдэх 82.8 хувь нь ямар нэгэн байдлаар хүчирхийлэлд өртөж байсан гэж хариулжээ. Тэдний 62 хувь нь үг хэлээр доромжлох, 50.2 хувь нь чимхэх, 43.5 хувь нь цохиж зодох зэрэг бие махбод, сэтгэл санааны хүчирхийлэлд өртсөн байна. Мөн тэдний 27,8 хувь нь үл хайхрах, 24.8 нь доромжлох, 22.9 хувь нь айлган сүрдүүлэх, 17.1 хувь нь ялгаварлан гадуурхах, 14.7 хувь нь бэлгийн шинжтэй дарамт халдлага үйлдэх, 5.9 хувь нь хүнд нөхцөлд ажил хийлгэх, 4.8 хувь нь гэрээсээ хөөгдөх зэрэг хүчирхийлэлд өртөж байснаа дурджээ. Эдгээр дүнг нэгтгээд үзвэл, 10 хүүхэд тутмын 8 нь ямар нэгэн хүчирхийлэлд өртсөн ба давтамжийн хувьд бие махбодийн хүчирхийлэлд хамгийн их өртдөг, энэ нь гэр бүл, сургуулийн орчинд хамгийн их гардаг байна. Асуулгад хамрагдсан 2 хүүхэд тутмын 1 нь амьдарч буй орчноо аюулгүй, хамгаалагдсан гэж үздэггүй бөгөөд 38.3 хувь нь сургуулийн орчноос (багш, сургуулийн атаман, нийгмийн ажилтан, дотуур байрны багшаас) хамгийн их айдаг хэмээжээ³. Сургуулийн орчинд хүүхдийн эрхийг зөрчиж, хүчирхийлэл үйлдэгч гол этгээдээр дээд ангийн хүүхэд (47.6 хувь), багш (15 хувь) гэж хариулсан⁴ байгаа нь хүүхдийн хоёр дахь “гэр” болсон газар нь аюулгүй, хүүхдэд ээлтэй бус байгаагийн илрэл юм. Сургууль дээрх дарамт хүчирхийлэл нь багш болон бусад сурагчдын зүгээс дээрэлхэх, дарамтлах, хүчирхийлэх үйлдэл юм. Дээрх судалгааны үр дүн бусад байгууллагуудын хийсэн судалгаануудаар⁵ ч мөн батлагдаж байгаа нь харамсалтай. Сургуулийн орчинд зарим багш, ажилтан хүүхдийн эрхийг ноцтойгоор

- 1 Хүүхдийн эсрэг хүчирхийлэл- Санаатай эсвэл санамсаргүйгээр хүүхдийн амь нас, эрүүл мэнд, хөгжил, бие махбод, сэтгэл санаанд хор хохирол учруулах үл хайхрах байдал, бэлгийн зүй бус үйлдэл, болон бие махбодийн шийтгэл, сэтгэл санааны дарамтыг хэлнэ. (Хүүхэд хамгааллын тухай хуулийн 4-р зүйл, 4.1.8 дахь хэсэг)
- 2 Монгол улс дахь хүний эрхийн нөхцөл байдлын талаарх 16 дахь илтгэл, ХЭҮК 2017 он, 13 дахь тал
- 3 Мөн тэнд, 14 дэх тал
- 4 Мөн тэнд, 16 дахь тал
- 5 ХИС, “Өсвөр үеийнхний дуу хоолой”судалгаа, 2017 он, Демокрейти залуусын төв ТББ “Залуусын дундах хүчирхийллийн судалгаа” 2018 он, Өөрчлөлтийн салхи ТББ “Оюутан залуусын дундах дарамт, дээрэлхэлтийн асуудал” 2018 он

зөрчиж, хүүхдүүд багшаасаа, үе тэнгийнхнээсээ айж, эмээж түгшдэг нь бусад судалгааны⁶ үр дүнгээр ч гарчээ.

Өнөөгийн байдлаар сургуулийн орчинд (дотуур байрыг оролцуулан) аюулгүй байдлыг төрөөс тодорхой хэмжээнд анхаарч байгаа бөгөөд БСШУСЯ-ны сайдын тушаалаар ЕБС-ийн орчин дахь хүүхэд хамгааллын бодлого⁷, Боловсролын байгууллагын сургалтын орчин, дотуур байранд хүүхэд хүчирхийлэлд өртөхөөс урьдчилан сэргийлэх журам⁸ зэргийг боловсруулж батлаад байна. Гэвч эдгээр баримт бичиг үе тэнгийхний дундах дарамт дээрэлхэлтээс урьдчилан сэргийлэх практик ач холбогдолгүйн дээр энэ агуулгын талаар нэгдсэн ойлголтыг сургуулийн удирдлага, багш, гэр бүл, асран хамгаалагч болон сурагчдад өгөөгүй байгаа нь сургуулийн орчинд гарч буй хүчирхийлэлд хариу арга хэмжээ авах, хүчирхийллийн соёлыг өөрчлөх, багш сурагчдын хандлага, өдөр тутмын практик үйл ажиллагаанд өөрчлөлт боломжгүй болгож байна. Сургууль хүүхдэд боловсрол эзэмшүүлэхээс гадна эрх нь зөрчигдөхөөс хамгаалах үүргийг мөн хүлээдэг⁹. Гэтэл хүний эрхийн болон хүүхдийн эрхийн нөхцөл байдлын судалгаануудаас үзэхэд, сурагчид сургууль, дотуур байрандаа үе тэнгийн дээрэлхэлтэд өртөх, ялгаварлан гадуурхагдах, хүчирхийлэл, гэмт хэрэгт холбогдох эрсдэлтэй байгаа нь хүүхдийн эрхийн зөрчлийг бууруулахгүй юм.

Хүчирхийлэл бол хувь хүний төрөлхийн шинж чанар гэхээс илүүтэй хувь хүн, гэр бүл, орчин хүрээлэл, нийгмийн хүчин зүйлсийн нөлөөгөөр бий болдог, төлөвшдөг хандлага, зан үйл юм. Хэвшсэн зан үйлийг өөрчилж болохоос гадна сөрөг зан үйлийг хэвшихээс нь өмнө урьдчилан сэргийлэх боломжтой билээ. Хүчирхийлэл гарахад нөлөөлж байгаа хүчин зүйлсийн нөлөөллөөс хамгаалах үйл ажиллагаа хэрэгжүүлснээр зан үйлийг өөрчилж, улмаар хүчирхийлэл гаргахаас нь өмнө урьдчилан сэргийлж болно. Сургуулийн орчинд гарч буй үе тэнгийнхний хүчирхийлэлд хариу арга хэмжээ авахгүй байгаа нь хүчирхийлэл бүхий л орчинд газар авч байгаагийн гол шалтгаан болж байна. Сургуулийн орчинд ялангуяа эрэгтэй сурагчдын дунд насаар бага сурагчдаас мөнгө нэхэж дарамтлах, өгөхгүй бол зодож гар хүрэх явдал нийтлэг. Охидын хувьд цахим орчны дээрэлхэлт, гадуурхалтад суурилсан сэтгэл санааны дарамт хүчирхийлэл элбэг байна. Зарим тохиолдолд үүнийг ангийн багш нь мэдэж байгаа ч ямар нэг арга хэмжээ авахгүй, эсвэл хэрхэхээ мэдэхгүй байгаа нь үе тэнгийнхний дарамт хүчирхийлэл буурахгүй байх шалтгаан болж байна.

Насанд хүрэгчдийн зүгээс сургууль, гэр бүлийн орчинд хүүхдийг хичээл хийх ёстой, сайн сур гэдэг шаардлагыг маш өндөр тавьдаг боловч бусадтай зөв харилцах, үе тэнгийнхэнтэйгээ хэрхэн зүй зохистой харилцах, зөрчил маргааныг хэрхэн хүчирхийллийн бус аргаар шийдвэрлэх арга замыг заах, эерэг зан байдлыг төлөвшүүлэх тал дээр учир дутагдалтай. Хүүхэд наснаасаа найз нөхөд, үе тэнгийнхнээ ойлгож, хүлээн зөвшөөрч, хүндэлж сурах нь ирээдүйд бусадтай зүй зохистой харилцдаг, багаар ажиллах, бусадтай хамтрах чадвартай бие хүн болон төлөвших суурь хандлага нь болох юм.

Монгол улсад хүн амын нийгэмд хүн амын нийгэм-эдийн засгийн хувьд ялгаатай бүлгүүдийн давхраажилт бий болж, тэгш бус байдал ихэсч, тэр дундаа маргинал¹⁰ бүлгийн хүүхэд залууст боловсрол эзэмших, цаашлаад хүний дайтай амьдрахад сорилт бэрхшээлүүд тулгарч байна. Нийгмийн тэгш бус байдалд ядуурал, нас, хүйс, үндэс угсаа, жендэр, нийгмийн гарал байдал, боловсролын түвшин хөгжлийн бэрхшээл болон оршин суугаа газарзүйн байршил зэрэг олон хүчин зүйл шууд, шууд бусаар нөлөөлж байна. Тэгш бус байдал гүнзгийрснээр эрх мэдлийн хувьд ялгаатай бүлгүүдийн хувьд ялгаварлан гадуурхалтыг ихэсгэж, улмаар жендэрт суурилсан болон бусад хэлбэрийн хүчирхийллийн соёлыг даамжруулж байна. Жендэрт суурилсан хүчирхийлэл, залуучуудын дундах хүчирхийлэл аливаа улс орны эрүүл мэнд, нийгмийн халамж болон хууль, шүүхийн салбаруудад илүү зардал үүсгэж, бүтээмжийг бууруулан, үр ашгийг багасгахад хүргэдэг.

6 Хүний эрхийн нөхцөл байдлын талаарх 16 дахь илтгэл, ХЭҮК, 2017 он

7 БСШУЯ-ны сайдын А/476 дугаарт тушаалаар 2018 оны 7 сарын 31-нд баталсан.

8 <https://www.legalinfo.mn/annex/details/8429?lawid=13346> Боловсролын байгууллагын сургалтын орчин, дотуур байранд хүүхэд хүчирхийлэлд өртөхөөс урьдчилан сэргийлэх журам

9 Боловсролын тухай хууль 44.2.4, Бага, дунд боловсролын тухай хууль 20.2.15, Хүүхэд хамгааллын тухай хууль 1.1

10 Маргинал бүлэг- Нийгмийн тэгш бус байдлаас үүдэлтэйгээр урт хугацаанд гадуурхагдаж, боловсролын бодлого, төсөвлөлтийн хийдлээс сурч боловсрох эрх нь зөрчигдсөн бүлэг.

Сургууль хэний ч хувьд аюулгүй орчин байх ёстой. Сургууль бол хүүхэд амьдралынхаа ихэнх цаг хугацааг өнгөрөөдөг, хүмүүжил төлөвшил, ертөнцийг үзэх үзлээ олж авдаг онцгой орчин. Сургуулийн орчинг материаллаг материаллаг бус (засаглалын, нийгэм сэтгэлзүйн) хэмээн хувааж үздэг. Материаллаг орчинд сургуулийн барилга байгууламж, анги танхим, бие засах газар гэх мэт сургуулийн үйл ажиллагаа явагддаг орчин бөгөөд мөн сургалтын хөтөлбөр, сурах бичиг, хичээлийн бусад хэрэглэгдэхүүнүүд ч орно. Харин сургуулийн материаллаг бус орчин буюу засаглал болон нийгэм, сэтгэл зүй нь харилцааны болон сургуулийн соёл, уур амьсгалыг хэмжиж байдаг маш чухал орчин юм. Засаглалын орчинд сургуулийн эрх зүйн орчин, сургуулийн удирдлагын шийдвэр болон үйл ажиллагаа, хөтөлбөр орох бол нийгэм сэтгэлзүйд багш хүүхдийн харилцаа, хандлага, эрх мэдлийн харилцаа, хүүхэд хоорондын харилцаа, багш, эцэг эх, асран хамгаалагчийн харилцаа, хүүхдийн оролцоо, хөгжил зэргээс бүрддэг. Дээрх сургуулийн материаллаг болон материаллаг бус орчныг зөв таатайгаар бүрдүүлэх нь сургуулийн орчин дахь аюулгүй байдлыг хангах суурь болж өгдөг билээ.

Сургуулийн материаллаг бус орчныг сайжруулах, хүүхэд хамгааллын бодлогыг хэрэгжүүлэх чиглэлээр “Боловсролын байгууллагын сургалтын орчин, дотуур байранд хүүхэд хүчирхийлэлд өртөхөөс урьдчилан сэргийлэх журам”¹¹-ыг баталсан байдаг. Энд баримт бичигт сургуулийн орчинд хүчирхийллээс урьдчилан сэргийлэх чиглэлээр авч хэрэгжүүлэх үйл ажиллагааг тусгаж өгснөөрөө онцлогтой. Үүнд:

Цэцэрлэг, сургууль, дотуур байрын багш, ажилтан, эцэг эх, асран хамгаалагч, суралцагчдад хүүхдийн эрх, хамгаалал, харилцаа хандлагын талаар дор дурдсан чиглэлээр нөлөөллийн үйл ажиллагааг сургууль дээр зохион байгуулна.

3.1.1. Хүүхдийн эрх хамгааллын талаарх мэдлэг, ойлголтыг нэмэгдүүлэх;

3.1.2. Хүүхэд хүмүүжүүлэх, хүүхэдтэй харилцах эерэг харилцааны аргад суралцах;

3.1.3. Хүүхдэд сөрөг зан үйл төлөвшихөөс урьдчилан сэргийлж, эерэг зан үйлийг дэмжих;

3.1.4. Ялгаварлан гадуурхал, ялгаатай байдлын талаарх хүүхдийн мэдлэг, ойлголтыг нэмэгдүүлэх, үе тэнгийн дээрэлхэлтийг зогсоох, урьдчилан сэргийлэх чиглэлээр хөтөлбөр боловсруулж ажиллах;

3.1.5. Аливаа хүчирхийлэл, дарамт, дээрэлхэлтээс өөрийгөө болон бусдыг хамгаалах, сэтгэлзүйн бэрхшээлийг даван туулах чадвар олгох;

Дээрх үйл ажиллагааны чиглэл нь энэхүү гарын авлагын агуулгад бүрэн нийцэж буй бөгөөд сургуулийн засаглал, материаллаг, нийгэм сэтгэлзүйн орчныг хүүхдийн эрхэд ээлтэй, аюулгүй болгох арга, аргачлалыг багтааснаараа онцлогтой.

Сургуулийн засаглалын орчин хэдий чинээ сайн байна төдий чинээ нөгөө хоёр орчин сайжирдаг гэсэн туршлага бий. Тиймээс бид энэхүү гарын авлагадаа “Үе тэнгийн дарамт, дээрэлхэлтээс урьдчилан сэргийлэх журам”-ын загварыг боловсруулсан билээ. Сургуулийн орчны үе тэнгийнхний дарамт, дээрэлхэлт, хүчирхийлэлд шоглох, заналхийлэх, цохих, тохуурхах, эд зүйлийг нь хулгайлах, нуух зэрэг шууд үйлдэл болон нэгнийхээ талаар цуу яриа тарааж тухайн сурагчийг нийгмээс тусгаарлагдахад нөлөөлөх шууд бус үйлдлүүд орно. Мөн энэ үйлдлүүд цахим орчинд ч үйлдэгддэг. Хүчирхийлэлтэй нүүр тулсан залуус хичээлдээ явах хүсэлгүй болох, хорт зуршилд автах, гадуур сэлгүүцэх, сургууль завсардахад хүрдэг. Сэтгэл санааны хувьд маш хүнд байдалд орж, улмаар сэтгэцийн эрүүл мэндийн ноцтой байдал үүсэж, насан туршийнх нь амьдралд нөлөөлөх эрсдэлтэй. Олон улсын түвшинд залуучуудын дундах хүчирхийллийг (өсвөр насныхан, үе тэнгийнхний дээрэлхэлт, хүчирхийлэл) нийгмийн эрүүл мэндийн ноцтой асуудал гэж үзэх болсон.

Дэлхийн эрүүл мэндийн байгууллагын судалгаанд дэлхий даяар нас баралт, хөгжлийн бэрхшээлийн нэг гол шалтгаан болоод байгаа хүчирхийллийн улмаас жил бүр 1.6 сая хүн нас барж байгаагийн 54% нь амиа хорлох, 35 хувь нь бусдын гарт амиа алдаж, 11% нь дайн, зэвсэгт мөргөлдөөн зэрэг бүлгийн хүчирхийлэлд өртөж байна гэсэн байдаг. БСШУЯ-ны

11 Боловсрол, соёл, шинжлэх ухаан, спортын сайдын 2018 оны 5 дугаар сарын 1-ны өдрийн А/239 тоот тушаалын хавсралт

судалгаагаар Монгол улсад дөрвөн сурагч тутмын нэг нь хүчирхийлэлд өртдөг, 6-12-р ангийн сурагчдын 98.6% нь сургуулийн орчинд ямар нэгэн төрлийн хүчирхийлэлд өртдөг ба үйлдэж буй гол субъект нь үе тэнгийнхэн нь байдаг байна.

ЯЛГААТАЙ БАЙДЛЫГ ХҮНДЭТГЭЖ, ХҮНИЙ ЭРХИЙН ХАНДЛАГЫГ ТӨЛӨВШҮҮЛЭХ НЬ

Боловсрол бол хүний үндсэн эрх төдийгүй бусад эрх, эрх чөлөөгөө эдлэх хамгийн чухал эх сурвалж юм. Боловсрол нь чадавхын эрх болохын хувьд нийгэм, эдийн засгийн хувьд хязгаарлагдмал хүүхдүүд, томчуудад ядуурлаас өөрсдийгөө гаргах, нийгмийн амьдралд бүрэн төгс оролцох арга замаа олох үндсэн хэрэгсэл нь болдог. Боловсрол нь эмэгтэйчүүдийг чадавхжуулах, хүнд, хортой хөдөлмөр, бэлгийн мөлжлөгөөс хүүхдүүдийг хамгаалах болон хүний эрх, ардчиллыг хөхүүлэн дэмжих, хүрээлэн буй орчноо хамгаалах, хүн амын өсөлтийг хянахад нэн чухал үүрэгтэй. Боловсрол нь төрийн санхүүгийн хөрөнгө оруулалтуудаас хийж болох хамгийн сайн хөрөнгө оруулалтын нэг хэмээн хүлээн зөвшөөрөгддөг. Гэвч боловсролын ач холбогдол нь зөвхөн практик зүйл биш. Чөлөөтэй, өргөн хүрээтэй сэтгэх чадвар бүхий сайн боловсрол эзэмшсэн, идэвхтэй санаа бодолтой хүн л хүн болж төрсний гавьяа, аз жаргалыг мэдэрдэг. Харамсалтай нь ялгаатай байдлыг хүлээн зөвшөөрөх мэдлэг, хандлага, ойлголт дутагдсанаар ялгаварлан гадуурхалт бий болж үүнээс үүдэлтэй саад бэрхшээлүүд хүүхдүүдийг амжилттай суралцах, өөртөө итгэлтэй хувь хүн болж төлөвшихөд саад болж цаашлаад сургууль завсардах нөхцөл болж байна. Боловсрол эвслийн хийсэн судалгаагаар¹² жендэрт суурилсан хүчирхийлэл, ялгаварлан гадуурхалт, үе тэнгийхний дээрэлхэлт нь сургуулиас гарах үндсэн шалтгаануудын нэг болох нь батлагдсан. Боловсролын зорилгыг ЭЗНСОУП-д тодорхойлсноор:

- (a) хүүхдийг бие хүн болгон төлөвшүүлэх, авьяас билэг, оюуны болон биеийн чадавхыг бүрэн төгс хөгжүүлэх;
- (b) хүний эрх, үндсэн эрх чөлөө болон Нэгдсэн Үндэстний Байгууллагын дүрэмд тунхагласан зарчмыг хүндэтгэх үзлээр хүмүүжүүлэх;
- (c) эцэг эх, соёл, хэл, үнэт зүйлс, амьдарч байгаа улсынхаа болон төрсөн улс орныхоо үндэсний үнэт зүйлс болон өөрийнхөөсөө ялгаатай соёл иргэншлийг хүндэтгэх үзлийг төлөвшүүлэн хөгжүүлэх;
- (d) харилцан ойлголцол, энхийг эрхэмлэх, хүлцэн тэвчих, эрэгтэй, эмэгтэйчүүдийн эрх тэгш байдал, аливаа ард түмэн, угсаатны болон шашны бүлэг, нутгийн уугуул иргэдийг хүндэтгэх үзлийг хүүхдэд төлөвшүүлж чөлөөт нийгэмд хариуцлагатай амьдрахад бэлтгэх;
- (e) байгаль орчныг хайрлан хүндэтгэх үзлээр хүмүүжүүлэх юм. Тиймээс боловсролын орчин буюу сургууль айдас, ялгаварлан гадуурхалт, хүчирхийллээс ангид байх ёстой. Нөгөө талаар Монгол улсын хууль тогтоомжид зааснаар боловсролын байгууллага, эцэг эх, асран хамгаалагч насанд хүрэгчид нь хүүхдийг дараах үйлдэл, эс үйлдлээс хамгаалах үүрэг хүлээсэн байдаг. Үүнд: аливаа төрлийн хүчирхийлэл, үл хайхрах, дарамт, мөлжлөг, эрсдэлт нөхцөл, гэмт хэрэг, зөрчил, бие махбодийн шийтгэл, хорт зуршилд өртөхгүй байх зэрэг багтана.

Ялгаатай байдлыг хүлээн зөвшөөрөх агуулга нь соёлын, нийгмийн, бие махбодын, эдийн засгийн, улс төрийн болон шашны эх сурвалжтай бөгөөд өөр бусдыг үл хүлцэх нь хүчирхийлэл болон ялгаварлан гадуурхалтын гол эх болдог. Үүнээс урьдчилан сэргийлэхэд хүлээцтэй байдал тэр дундаа хүний эрх, эрхэм чанар, ялгаатай байдлыг хүндлэх, зөрчлийг хүчирхийллийн бус арга замаар шийдвэрлэх чадварыг төлөвшүүлэх цогц, ухаалаг арга зүйг нэвтрүүлэх нь боловсролын салбарын эн тэргүүний зорилт байх ёстой. Бидэнд нийтлэг байдаг ганцхан зүйл бол ялгаатай байдал юм. Хөгжлийн бэрхшээлтэй хүмүүс болон хүүхдүүдийг ялгаварладаг тогтолцоо нь хэн бүхнийг хүйс, нас, оршин буй газар, ядуурал, нийгмийн статус, үндэс угсаа, харьяалал, хэл, шашин, шилжин ирсэн эсвэл дүрвэсэн байдал, бэлгийн чиг баримжаа, жендэр, шоронд

12 “Тодорхой бүлгийн хүүхдүүдэд боловсрол эзэмшихэд тулгардаг саад тотгорууд” чанарын судалгаа, 2020 он

хоригдсон явдал төдийгүй итгэл үнэмшил мөн хандлагаас нь болж гадуурхаж байдаг.¹³ Энэхүү агуулгыг ТХЗ-ын 4.7-д “Бүх суралцагчдад тогтвортой хөгжил болон тогтвортой амьдралын хэв маягийн тухай боловсрол, хүний эрх, жендэрийн тэгш эрхийн боловсрол, энх тайвныг эрхэмлэх болон үл хүчирхийлэх соёл, дэлхийн иргэн байх болон соёлын олон янз ялгаатай байдлыг дээдлэх хандлагыг түгээх замаар тогтвортой хөгжлийг бий болгох мэдлэг, ур чадварыг эзэмшүүлсэн байна” хэмээн тодорхойлсон билээ.


Нийгмийн ялгаатай байдал¹⁴ гэдэгт бид дараах агуулгыг ойлгодог.

Ялгаатай байдал	Агуулга
 <p>Жендэр</p>	Хүмүүс хүйс, бэлгийн чиг баримжаа, хүйсийн баримжаа илэрхийллээрээ ялгаатай боловч аливаа нийгмийн харилцаанд тэгш оролцох, өөрийгөө илэрхийлэх сонголтоо чөлөөтэй хийх боломжоор хангагдсан байх ёстой.
 <p>Нийгэм - эдийн засгийн статус</p>	Нийгэм- эдийн засгийн статус нь хувь хүн болон гэр бүлийн эрхэлдэг ажил, мэргэжил, боловсрол, орлогын түвшингээр тодорхойлогддог нийгэм болон эдийн засагт эзлэх байр суурь юм. Хүн бүр өөрийн болон өөрийн төрсөн гэр бүлийн нийгэм - эдийн засгийн байр сууриасаа үл хамааран нийгмийн баялгаас хүртэх эрхтэй.
 <p>Хөгжлийн бэрхшээл</p>	Хөгжлийн бэрхшээл гэдэг нь хүн бие махбод, оюун санаа, сэтгэл мэдрэл, мэдрэхүйн байнгын согог нь орчны бусад саадтай нийлсний улмаас бусдын адил нийгмийн амьдралд оролцох чадвар нь хязгаарлагдсан байдлыг хэлнэ. Хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийн нийгмийн харилцаанд тэгш боломжтой, ялгаварлан гадуурхалтаас ангид байх эхний алхам бол тэднийг нийгмийн бүхий л хүрээнд ил харуулах буюу “үл үзэгдэгч” статусыг нь өөрчлөх явдал юм.
 <p>Үндэс угсаа, хэл соёл</p>	Аливаа үндэс угсаа, хэл соёл түүнд хамаарах хүний тооны олон болон цөөнөөс үл хамааран нийгэмд ижил тэгш хүндэлж, хүлээн зөвшөөрөх ёстой.
 <p>Төрсөн \өссөн\ амьдардаг газар</p>	Шууд утгаараа газарзүйн байршил, өргөн утгаараа боломж, зах зээл, урлаг, соёлын төвлөрөлд ойр эсвэл хол, нийгмийн баялгийг хүртэх бололцоо өргөн эсвэл хомс газарт төрөх, өсөх, амьдрах нь хувь хүний сонголтоос маш багаар шалтгаалах бөгөөд хаана төрсөн, өссөн болон амьдардагасаа үл шалтгаалан нийгмийн харилцаанд тэгш боломжоор оролцох эрх хүн бүрт бий.
 <p>Шашин</p>	Хүн бүр шашин шүтэх эс шүтэх эрхтэй. Энэхүү эрхийг хангах гол үндэс болсон төрийн үйл ажиллагаа шашнаас ангид байх Үндсэн хуулийн зарчим нь боловсролын үйл ажиллагаа, агуулгын ч гол зарчим болно.
 <p>Нас</p>	Хүн бүр өөрийн наснаас буюу тухайн настай холбоотой хэвшмэл ойлголтоос ангид өөрийгөө эрэлхийлэх, илэрхийлэх, хүндлэгдэх нийгмийн амьдралд чөлөөтэй оролцох тэгш боломжтой байх ёстой бөгөөд насны онцлогоосоо хамаарсан хэрэгцээгээ хангах боломжтой байх ёстой.

¹³ “Боловсролын хяналт мониторингийн дэлхийн тайлан 2020”, ЮНЕСКО

¹⁴ “Нийгмийн ялгаатай байдлыг сургалтын хөтөлбөр, сурах бичигт тусгах удирдамж” Боловсрол эвсэл, 2017 он

ҮЕ ТЭНГИЙН ДЭЭРЭЛХЭЛТИЙН ЭСРЭГ АВЧ ХЭРЭГЖҮҮЛЭХ АРГА ХЭМЖЭЭНИЙ ҮЕ ШАТУУД



Үе тэнгийн дарамт, дээрэлхэлтийг зогсоох сургуулийн манлайлал



ДЭЭРЭЛХЭЛТЭЭС УРЬДЧИЛАН СЭРГИЙЛЭХ АРГА ЗАМ

Үе тэнгийн дарамт, дээрэлхэлт бол зөвхөн суралцагчдын асуудал биш юм. Энэ нь өргөн хүрээгээрээ нийгмийн, явцуугаар сургуулийн бүх хүний асуудал билээ. Сургууль дээрх үе тэнгийн дарамт, дээрэлхэлтийн асуудалтай тэмцэхэд сургуулийн орчны манлайлагчид болох сургалтын менежер, нийгмийн ажилтан, анги удирдсан багш, эцэг эхийн зөвлөл/сургуулийн эцэг эх, асран хамгаалагч, багшийн холбоо, сурагчдын зөвлөл, сургуулийн аж ахуй, үйлчилгээний албаны ажилчид (бүгдийг нийлүүлээд сургуулийн хамт олон гэж үздэг) төдийгүй хороо, дүүрэг зэрэг хамаарагдаж болох бүх хүний оролцоо, манлайлал, чин зүтгэл чухал үүрэгтэй.

Сургууль дээрх манлайлагчид үе тэнгийн дээрэлхэлтээс урьдчилан сэргийлэх болон дээрэлхэлттэй тэмцэхдээ доорх үндсэн 7 зарчмыг үйл ажиллагаандаа баримтлан ажиллаарай.

ЗАРЧИМ 1. СУРГУУЛИЙН ЭЭРЭГ УУР АМЬСГАЛ, ХҮЧИРХИЙЛЛИЙГ ҮЛ ТЭВЧИХ СОЁЛ БҮЮУ ЭЭРЭГ ХАНДЛАГА ТӨЛӨВШҮҮЛЭХ НЬ

Үе тэнгийнхний дээрэлхэлтээс урьдчилан сэргийлэх тулгын чулуу нь сургуулийн зүгээс ялгаатай байдлыг адил тэгш, хүндэтгэн хүлээн авдаг, бүх хүүхдийг тэгш хамруулдаг уур амьсгал бүрдүүлэх явдал юм. Сургуулийн эерэг соёлд хамгийн чухал нь сургууль даяар бие бие хүндэтгэсэн харилцаатай байх явдал юм. Энэ нь үе тэнгийнхний дунд (жишээ нь: багш хоорондын, сурагч хоорондын) болон бүлэг хоорондын (багш-сурагч, багш - эцэг эх, асран хамгаалагч хоорондын) харилцаа эерэг уур амьсгалтай байхыг ойлгоно. Тиймээс та бүхэн “дээрэлхэлт нь хүүхдийн хөгжлийн хэвийн үе шат бөгөөд хүүхдийг тэсвэр хатуужилтай болоход сургадаг” гэдэг үзлээсээ салах хэрэгтэй. Сурагчид дээрэлхэлтийн тохиолдлуудыг санаа зовох зүйлгүй илчлэх, ярилцах боломжтой нөхцөлийг бий болгохыг тэмүүлэх нь сургуулийн болон насанд хүрэгчдийн үүрэг юм. Үүний үр дүнд сурагчид ч мөн бие биенийхээ аюулгүй, сайн сайхан байдалд анхаарах үүрэг хариуцлагатай гэдгээ ухаарах боломжийг олгодог.

Сургуулийн зүгээс сургуулийн бүх ажилтан, сурагчид хоорондоо нээлттэй ярилцахыг дэмжих ёстой бөгөөд сургуулиуд сурагчдадаа санаа бодлоо хэнтэй ч нээлттэйгээр хуваалцах боломж нөхцөлийг олгодог байх хэрэгтэй. Үүний тулд сургуулийн орчноос гадуур болдог асуудлууд, ялангуяа цахим дээрэлхэлтийн асуудлуудыг заавал оруулах хэрэгтэй. Сургууль бодлого, дүрэм журмандаа сөрөг хандлага болон чимээгүй байдал, соёл зэргээр халхлагддаг гомофоби, дээрэлхэлт зэрэг асуудлуудыг хэрхэн тусгахаа бодох хэрэгтэй.



Сургууль дээрээ хэрхэн найрсаг уур амьсгал бүрдүүлж хүчирхийллийг үл тэвчих соёлтой сургуулийг бий болгох тухай практик зөвлөмж

- Сургуулийн бүх гишүүд цаг ямагт эерэг зан үйлийг өөрийн биеэр үлгэрлэн үзүүлнэ.
- Ангид болон сургуулийн эргэн тойронд бусдыг хүндэтгэсэн үг хэллэг, хэл яриа болон бусдад хүндэтгэлтэй хандаж буй зан үйл хэрхэн харагддагийг, яаж үйлддэгийг, ямар сонсогддогийг, бусдад болон өөрт хэрхэн мэдрэгддэгийг сурагчдадаа маш тодорхой ойлгомжтойгоор зааж сургана.
- Анги танхим, цайны газар, спорт зал гэх мэт олноор цуглардаг газар, сургуулийн эргэн тойронд бие биенээ хүндэтгэхийг уриалсан мессежүүдийг байршуулна. Үүнийг хэрэгжүүлэхдээ сурагчдыг татан оролцуулна.
- Үлгэр жишээ биеэ авч яваа сурагчдыг анзаарч бусдад үлгэр жишээ байгаад нь талархаж байгаагаа илэрхийлнэ.
- Сургуулийн орчинд ялгаварлан гадуурхсан мөн гутаан доромжилсон үг хэллэг хэлсэн үед тухайлбал гомофобик болон нийгмийн гарал үүслээр гадуурхсан үг хэллэг, хөгжлийн

бэрхшээлтэй эсхүл тусгай хэрэгцээт боловсролтой хүүхдийг гутаан доромжилсон үг хэллэг хэрэглэсэн тохиолдолд нэн даруй таслан зогсоох тохирсон арга хэмжээг авдаг байх хэрэгтэй.

- Хүндэтгэлтэй зан үйлийг үйлдэхгүй эсвэл хүндэтгэлтэй үг хэллэг ашиглахгүй байгаа сурагчдад онцгойлон явал зөв болохыг хэлж ойлгуулна.
- Сургуулийн дүрэм журам болон тогтсон дэгийн дагуу зөв зан үйлийг уриалан дэмждэг урамшууллын системтэй болно.
- Нийгмийн сүлжээ, цахим орчинд хэрхэн зохистой биеэ авч явах, зохистой үг хэллэг хэрэглэх талаар сургуулийн бүх гишүүдэд тодорхой ойлгомжтой зааж сургана.
- Сурагчдыг гар утас болон интернет хэрэглээ дээрээ сургуулийн дүрэм журмыг дагаж мөрдөхийг хөхүүлэн дэмжинэ. Журмыг мөрдөж байгаа эсэхэд мөн журмыг зөрчиж байгаа сурагчдад хяналт тавина.
- Эцэг эх, асран хамгаалагчид болон эцэг эхийн зөвлөл/сургуулийн эцэг эх, багшийн холбоог нийгмийн сүлжээг зохистой ашиглах кампанит ажилд өргөнөөр татан оролцуулна
- Сургуульд хамаарах гишүүн бүр аюулгүй, амар тайван байх эрхтэй гэдгийг эрчимтэйгээр түгээн дэлгэрүүлнэ.
- Бүх ажилтнууд дээрэлхэлтийн зан үйлийн шинж тэмдгүүдийг таньж мэддэг, анхааралтайгаар харж ажиглаж байхад сургана
- Сургуулийн тоглоомын талбай, хашаа, гадаа орчинд хангалттай хараа хяналт байна уу гэдгийг нягтална.
- Сургуулийн ажилчид дээрэлхэлтийн халуун цэг болон оргил цагуудыг илрүүлэхэд сурагчдын тусламжийг авах, мөн эцэг эх, асран хамгаалагчдыг дайчлан (school police) халуун цэг, оргил цагийн үед ажиллуулна.

Халуун цэгүүдэд: тоглоомын талбай, сургуулийн гадаа талбай, хувцас солих өрөө, 00 өрөө, коридор, шатны хонгил, сургуулийн автобус зэрэг хараа хяналт сул газрууд

Оргил цаг: Насанд хүрэгчдийн хараа хяналт сулрах үеэр дутуу чимээ ихтэй урлаг, спортын арга хэмжээний үе, тоглоомын талбай, гадаа талбай, завсарлага, ангийн ээлж солигдох үе зэрэг гэх мэт

ЗАРЧИМ 2. ҮР ДҮНТЭЙ МАНЛАЙЛАЛ

Ялгаатай байдлыг хүндэлдэг, дэмждэг сургуулийн соёл, уур амьсгалыг бий болгохыг зорьдог үр дүнтэй манлайлал нь практикт маш чухал юм. Сургууль даяар дээрэлхэлтийг таслан зогсоох, дээрэлхэлтээс урьдчилан сэргийлэх үйл ажиллагаанд сургуулийн удирдлагын/ удирдах ажилтнуудын үүрэг их. Ялангуяа сургуулийн захирал нь сургуулийн орчны дээрэлхэлттэй тэмцэхэд хамгийн голлох үүрэгтэй. Учир нь захирал бол тиймэрхүү зан авирын эсрэг арга хэмжээ авахад тохиромжтой эрх мэдэл бүхий албан тушаал юм. Захирал болон сургуулийн бусад удирдагчид, ялангуяа багш нар дээрэлхэлтийг огт хүлээн зөвшөөрдөггүй сэтгэхүйг төлөвшүүлэх хэрэгтэй. Сургуулийн удирдлагад/удирдах ажилтнуудад тооцогдож буй хэн ч бай дээрэлхэлтийн эсрэг арга хэмжээг бодитоор авч хэрэгжүүлж чадна. Сургуулийн удирдагчид ялгаатай байдлыг хүлээн зөвшөөрсөн, үүнийг чухалчилсан уур амьсгал бүрдүүлэх алсын хараагаа сурагч, ажилтнууддаа ч мөн танилцуулж байх ёстой.

Сурагчид насанд хүрэгчдээс үлгэр дуурайлал авдаг учир захирал болон багш нар эрх мэдлийн давуу талаа урвуулан ашиглахгүй байх ёстой. Түүнчлэн дүрэм журам сахиулахдаа шударга, чанд, тодорхой, тууштай байх хэрэгтэй.

Сургууль дахь насанд хүрэгчид нь сурагчдын сурах үйл явцад үлгэр жишээ болж хүндлэл хүлээдэг учраас өөр хоорондоо харьцахдаа ч, сурагчидтайгаа харилцахдаа ч сургуулийн уур амьсгал, зан төлвийн жишиг хандлагыг тодорхойлж байдаг гэдгийг мартаж болохгүй. "Сурагчид ч бас хүндлэгдэх ёстой" гэсэн жишгийг эцэг эхчүүдэд үлгэрлэн үзүүлэх ёстой. Багш, эцэг эх, асран хамгаалагчдын гаргаж байгаа үйлдэл нь эерэг харилцааны үлгэр дуурайл болдог учир сургуулийн эерэг соёл, уур амьсгал бүрдүүлэхэд насанд хүрэгчдийн манлайлал чухал.

ЗАРЧИМ 3. ДЭЭРЭЛХЭЛТ БОЛОН ТҮҮНИЙ ХОР УРШГИЙН ТАЛААРХ НЭГДСЭН ОЙЛГОЛТ

Сургуулийн бүх гишүүд дээрэлхэх зан үйл гэж юу болох талаар нэгдсэн ойлголттой болохыг магадлах тогтолцоог ажиллуулах ёстой. Энэхүү нэгдсэн ойлголтыг бий болгох үйл явц нь сурагчдын нас, сэтгэхүйн онцлог зэрэг хүчин зүйлсээс хамаарна. Дээрэлхэлтийн тодорхойлолт, олон янзын хэлбэр, үр нөлөөг сургуулийн гишүүдэд ойлгуулж, тайлбарлаж өгөх хэрэгтэй.

Үе тэнгийн дээрэлхэлт, түүний төрөл хэлбэрийн талаарх баримт мэдээлэл¹⁵

Тодорхойлолт 1.	Тодорхойлолт 2.	Тодорхойлолт 3.
<p>“Бусдыг бие махбод, сэтгэл санааны хувьд зовоох зорилгоор ганцаар юмуу бүлэглэн давтамжтайгаар үйлдэх зан үйл”</p>	<p>“Өдөж уурлуулах, хочлох, элэглэн шоолох, айлгах, дарамтлах, өдөж хатгах, ангийн ялгаа гаргаж дарамтлах, ганцаардуулах, хов тараах зэрэг бие махбод, сэтгэл санааны түрэмгийллийг хэн нэгний эсрэг давтамжтайгаар үйлдэх үйлдэл”</p>	<p>“Эрх мэдлийн тэнцүү бус харилцаатай хүн, бүлгүүд нэгнийгээ зорилготойгоор, давтамжтайгаар зовоох үйлдлийг дээрэлхэлт гэж үзэх ба энэ нь биеэр болон цахим хэлбэрээр илэрч болно.”</p>

Хэн дээрэлхэлтийн хохирогч болох эрсдэлтэй вэ?

- Маргинал бүлгийн хүүхэд залуус (амьжиргааны баталгаажих түвшнээс доогуур орлоготой өрхийн хүүхдүүд, үндэсний цөөнх, бэлгийн цөөнх, шилжин суурьшигчид, дүрвэгсэд, хөгжлийн бэрхшээлтэй хүүхдүүд, гэмт хэрэгт холбогдсон хүүхдүүд, хүчирхийлэлд өртсөн хүүхдүүд гэх мэт)
- Охид, хөвгүүд, хэн бүхэн

Дээрэлхэлтийн төрлүүд

<p>Бие махбодийн</p> <p>Сул дорой байгааг нь мэдрүүлэх зорилгоор түлхэх, өшиглөх, цохих, алгадах, биеийн хүчирхийллийн бусад хэлбэрүүд</p>	<p>Ам хэлээр</p> <p>Өөрийг нь эсэргүүцэж чадахгүй байгааг харуулах зорилгоор хочлох, шоолох, хов тараах, дооглох</p>
<p>Гадурхалт</p> <p>Баг, бүлгээс мөн үйл ажиллагаанаас илт хасах, ганцаардуулах, интернэт, нийгмийн сүлжээнд нөгөө хүний талаар сөрөг пост нэргүй тавих, цуу үг, хов тараах, хувийн мэдээллийг нь олон нийтэд дэлгэх</p>	<p>Мөнгө нэхэх</p> <p>Эрх мэдэл нөлөөгөө мэдрүүлэх зорилгоор мөнгө олж ирэхийг шаардах, мөнгө эд зүйл, хоол хүнсийг нь авна гэж айлгах, булаах</p>
<p>Үгэн бус</p> <p>Нэр хүндийг гутаасан утга агуулгатай бичиг, зураг, дүрслэл хийх, үйл хөдлөл, дохио зангаа үзүүлэх</p>	<p>Эд хөрөнгөнд халдах</p> <p>Эрх мэдэл, нөлөөгөө мэдрүүлэх зорилгоор бусдын эд зүйлийг хулгайлах, нуух, эвдэх, устгах</p>

15 “Үе тэнгийн дээрэлхэлтийн эсрэг хакатон” баримт бичиг, 2018 он

ЗАРЧИМ 4. ДЭЭРЭЛХЭЛТИЙН ЭСРЭГ ЖУРАМ БУЮУ ДЭЭРЭЛХЭЛТИЙН ЗАН ҮЙЛИЙГ УСТГАХ МЕХАНИЗМ

Монгол улсын ерөнхий боловсролын сургууль бүр үе тэнгийн дарамт, дээрэлхэлтээс урьдчилан сэргийлэх журамтай (дээрэлхэлтийн эсрэг журам) байх хэрэгцээ шаардлага нь хүүхдийн эрх, хүүхэд хамгааллын хуулийн дагуу үүсэж буй. Бүх сургууль хүүхэд хамгааллын бодлогоо тодорхойлж, хамтарсан багтай эгэх харилцаа холбоотой ажилладаг. Үе тэнгийн дээрэлхэлт нь устгах боломжтой соёл, зан үйл, хандлага тул сургууль дээрх насанд хүрсэн манлайлагчдын тусламжтайгаар энэхүү хүүхдийн эрхийн зөрчлийг үгүй болгож болно. Сүүлийн жилүүдэд хувийн хэвшлийн зарим сургууль үе тэнгийн дарамт дээрэлхэлтийн эсрэг журам боловсруулсан байдаг бол улсын ЕБС-ийн хувьд цоо шинэ хүүхдийн эрхийн механизм гэж хэлэхэд хилсдэхгүй болов уу. Сургууль хэр эерэг уур амьсгалтай, ялгаатай байдлыг хүндэтгэж, хүний эрхийг дээдэлдэг соёлтой байна үе тэнгийн дээрэлхэлтээс урьдчилан сэргийлэх журам төдий чинээ сайн хэрэгжинэ гэж хүний эрхийн мэргэжилтнүүд үздэг.

Сургуулийн зөвлөл (удирдах зөвлөл) үе тэнгийн дээрэлхэлтийн эсрэг журмыг боловсруулахдаа сургуулийн багш, ажилтан, эцэг эх, асран хамгаалагч багш, сурагчдын (ялгаатай насны, ялгаатай хүйсийн төлөөллөөс) саналыг авч тусгах ёстой. Ингэж байж сургууль даяар авах арга хэмжээг холбогдох бүх этгээд хэрэгжүүлэх боломжтой болох юм. Хэрэв журам нь асуудлыг үр дүнтэй шийдвэрлэх үндсэн суурь нь болно гэж итгэж, үнэмшиж байвал холбогдох бүх этгээд журмын зорилго, агуулгыг тодорхой ойлгож байх нь чухал.

ҮЕ ТЭНГИЙН ДЭЭРЭЛХЭЛТЭЭС УРЬДЧИЛАН СЭРГИЙЛЭХ ЖУРМЫН ГОЛ ЗОРИЛГО:

- Сургууль дээр бүгдийг хамарсан, ээлтэй эерэг уур амьсгал, хүчирхийллийг үл тэвчих соёл бүрдүүлэх
- Сургууль даяар дээрэлхэлт нь байж болшгүй үйлдэл гэдэг ойлголтыг бий болгох (сургуулийн захиргаа, багш нар, сурагчид, эцэг эх, асран хамгаалагч, ажилтнууд, сайн дурын ажилтан гэх мэт)
- Дээрэлхэлтийн зан үйлийг илчилж, энэ талаар ярилцахыг уриалж, зоригжуулсан нээлттэй, дэмжлэг бүхий сургуулийн уур амьсгалыг бий болгох
- Сургуулийн үйл ажиллагааг бүхэлд нь хянаж байх удирдлага, хяналтын тогтолцоо бий болгох
- Дээрэлхэлтийн зан үйлийг цааш нь шалгах, арга хэмжээ авах горимыг бий болгох
- Дээрэлхэлтийн зан үйлийг тэмдэглэх, мэдээлэх горимыг бий болгох
- Дээрэлхэлтийн зан үйлд өртсөн, оролцсон хүмүүст зориулсан хөтөлбөр боловсруулах
- Орон нутгийн төрийн байгууллагуудтай хамтран дээрэлхэлтийн бүх хэлбэр, нийгмийн эсрэг зан үйлтэй хамтран тэмцэх
- Сургуулийн үе тэнгийн дарамтын эсрэг журмын хэрэгжилтийг байнга хянаж, үнэлэх өөрийн гэсэн тогтолцоог ажиллуулах юм.



Сургууль бүр үе тэнгийн дээрэлхэлтийн эсрэг журамдаа тухайн сургууль нь дээрэлхэлтийн онц ноцтой мөн чанар, сурагчдад үзүүлэх хор уршгийг таньж, ойлгож байгаа учраас үе тэнгийн дээрэлхэлтээс урьдчилан сэргийлэх, арга хэмжээ авахад шаардлагатай гол зарчмуудыг баримтална гэдгээ сургуулийн хамт олон, эцэг эх, асран хамгаалагч, сурагчдад ил тод, нээлттэй илэрхийлэх ёстой байдаг.

Сургууль дээрх эерэг уур амьсгал, соёлыг бүрдүүлэх үйл явц дараах зарчимтай байна. Үүнд,

- Олон янз, ялгаатай байдлыг хүлээн зөвшөөрч, бүгдийг тэгш хамруулсан байх
- Сурагчид үе тэнгийн дээрэлхэлтийн зан үйлийг илчлэх, ярилцах боломжтой аливаа айдас, заналхийлэлгүй орчныг бүрдүүлэх
- Сургуулийн хамт олон (сургуулийн харилцаанд оролцогч олон нийт) бие биеэ хүндэтгэсэн харилцааг дэмжиж нийтийг хамарсан хандлага, арга замыг хэрэгжүүлэх

Дээрэлхэлтийн талаарх нэгдсэн ойлголттой байх, сэтгэл зүйн болон хүний эрхийн боловсрол олгох, зөрчлөөс урьдчилан сэргийлэх арга замыг хэрэгжүүлэх (ойлголтыг нэмэгдүүлэх) гэх мэт үйл ажиллагаа чухал. Ялангуяа сургуулийн хамт олны бүх гишүүдийн эмпати (бусдын оронд өөрийгөө тавьж хандах), хүндэтгэл, сэтгэлийн тэнхээг нэмэгдүүлдэг байх, цахим дээрэлхэлт, ялангуяа гомофобик, трансфобик гэх мэт жендэрийн адилсалд үндэслэсэн дээрэлхэлтэнд онцгойлон анхаарч үздэг байхыг анхаарна.

Дээрэлхэлтээс урьдчилан сэргийлэх журам нь бусдыг хүндлэх, итгэх, халамжлан анхаарах, туслах зэргийг дэмждэг сургуульд хамгийн сайн хэрэгждэг.

Мөн сурагчдыг үр дүнтэй хянадаг байх (хяналтын тогтолцоо нь хүний эрх, хүүхдийн эрхэд суурилсан байх), ажилтнуудаа дэмжих, дээрэлхүү зан үйлийг тогтмол бүртгэж, нягтлан тогтоож, эргэж хянадаг байх (арга хэмжээ нь тогтмолжсон байх), дээрэлхэлтийн эсрэг журмыг байнга үнэлдэг, эргэх холбоотойгоор сайжруулдаг байх чухал юм.

Дээрэлхэлтээс урьдчилан сэргийлэх журмаа боловсруулахдаа сургуулийн бүх хүний дуу хоолойг сонсож тусгахын зэрэгцээ бий болгосон журмаа тогтмол хянаж үнэлэн шаардлагатай тохиолдолд шинэчилснээр дээрэлхэлтээс сэргийлэх, дээрэлхэлт гарсан тохиолдолд ямар арга хэмжээ авах стратеги, процедур, хийх ажлын хүрээг тодорхой болгодог.

Дээрэлхэлтээс урьдчилан сэргийлэх журмыг түгээх, танин мэдүүлэх

- Мэдээлэл сургуулийн ажилтнуудад хүрсэн байх, (гарын үсэг зуруулах зэргээр)
- Тухайн сургуулийн веб хуудсанд нээлттэй байршуулсан байх (веб хуудас байдаггүй бол эцэг эх, асран хамгаалагч болон сурагчдын хүссэн үед нь тарааж өгөхөд бэлэн байх),
- Эцэг эхийн зөвлөлд/сургуулийн эцэг эх, асран хамгаалагч багшийн холбоонд мэдээлэл хүрсэн байх хэрэгтэй.
- Сургуулийн удирдах зөвлөл нь журмыг сургууль даяар тогтмол таниулах тэр дундаа шилжин ирж буй сурагч болон тэдгээрийн эцэг эхэд тусгайлан танилцуулах ёстой.
- Сургуулийн орчин дахь дээрэлхэлтийн асуудлыг ямар багш хариуцаж байгааг сургалтын менежер сурагч, эцэг эх, асран хамгаалагч болон сургуулийн ажилтнуудад мэдэгдэх ёстой.
- Сургуулийн дүрэм болон бусад мэдээллийг сургуулийн орчинд сурагчдын насанд тохирсон хэлбэрээр байрлуулсан байх шаардлагатай.



Сургууль даяар хэрэгжүүлэх арга зам

Үе тэнгийн дарамт, дээрэлхэлттэй тэмцэх үйл ажиллагаа нь сургууль даяар (сургуулийн удирдлага, ажилтнууд, эцэг эх, сурагчид) хэрэгжиж байж үр дүнд хүрдэг гэдгийг хүлээн зөвшөөрөх хэрэгтэй. Дээрэлхэлт нь шууд оролцож байгаа хүмүүсээс гадна тухайн анги танхим, сургууль, цаашлаад орон нутаг, нийгэмд сөргөөр нөлөөлж байдаг.

Сургууль даяараа ижил хандлага, хариуцлагатай оролцоотой байвал дээрэлхэлтийн зан үйлтэй тэмцэхэд хавьгүй илүү үр дүнтэй юм. Сургуулийн удирдлага, багш, ажилтнуудаас гадна эцэг эх, асран хамгаалагч, сурагчид сургуулийн орчин дахь дээрэлхэлтээс урьдчилан сэргийлэх үйл ажиллагаа өрнүүлэх, сургуулиас гадуурх болон сургуулийн орчинд гарч буй дээрэлхэлтийн зан үйлээс гарч буй сөрөг нөлөөний эсрэг арга хэмжээ авах үүрэгтэй. Сургуулийн зүгээс дээрэлхэлтийн эсрэг арга хэмжээ авч, энэ асуудлуудыг хөндөх нь эерэг үр нөлөөтэй гэдгийг эцэг эх, асран хамгаалагчид ухамсарлан сургуультай хамтарч ажилласнаар сургуулийн зүгээс авч хэрэгжүүлж байгаа үйл ажиллагаа нь уялдаатай, сургууль даяар үр дүнтэй болж чадна. Дээрэлхэлт нь тодорхойгүй, нууцлаг орчинд даамжирдаг ба өөрийг нь дээрэлхэж байгаа хүний өмнөөс тэмцээд нэмэргүй, дэмий гэсэн цөхөрсөн мэдрэмж сурагчдад төрдөг байна. Тиймээс сургууль даяараа сонор сэрэмжтэй, нээлттэй байж дээрэлхэлтийн зан үйлийг үр дүнтэй зогсоох боломжтой.

Холбогдох субъектууд (гэр/ сургууль/орон нутгийн төрийн байгууллага зэрэг)-ыг дэмжих нь сургууль дээрэлхэлтийн зан үйлтэй тэмцэхэд чухал бөгөөд сургуулийн үр дүнтэй, үйл ажиллагааны нэг хэсэг юм. Жишээ нь, дээрэлхэлт сургууль руу явах болон сургуулиас гэртээ ирж очих замд тохиолдож болно шүү дээ.



Дээрэлхэлтээс урьдчилан сэргийлэх журмаа олон нийтэд танилцуулах нь олон талын ач холбогдолтойг бид дээрх жишээнээс харж болох байна. Дээрэлхэлтээс урьдчилан сэргийлэх, таслан зогсоох ажил нь олон нийтийн, олон талт оролцоог хангасан ажил юм.

5. УРЬДЧИЛАН СЭРГИЙЛЭХ, ОЙЛГОЛТ НЭМЭГДҮҮЛЭХ СТРАТЕГИ

Дээрэлхэлтийн эсрэг журам нь дараах зүйлсийг агуулсан байвал зохистой.

- Дээрэлхэлт гэж юу болох талаар тодорхойлолт, дээрэлхэлтийн төрлүүд
- Дээрэлхэлт бол хүлээн зөвшөөрөгдөхгүй зан үйл бөгөөд үл тэвчинэ гэсэн мэдэгдэл
- Дээрэлхэлтийн бүх тохиолдлуудыг сурагчид мэдэгдэж, бие биенээ дэмжих хэрэгтэй
- Дээрэлхэлтийн талаар ирсэн бүх мэдээллийг нягтлан шалгадаг, ингэхдээ ёс зүй, хүний эрхийг хүндэтгэсэн хандлагаар хандах
- Дээрэлхэлтийн сэжигтэй тохиолдол гарвал сургууль хэрхэн шийдвэрлэх талаар тодорхой мэдэгдэл хийж байх

Журам нь дээрэлхэлт гарсан тохиолдолд ямар үе шаттай арга хэмжээ авах талаар мөн хэн хариуцан ажиллах талаар дурьдсан байх хэрэгтэй. Мөн түүнчлэн дээрэлхэлтэд өртсөн хүүхэд, гэрчийн мэдүүлэг өгсөн хүүхэд хэрхэн дэмжлэг авах талаар тодорхой заасан байх хэрэгтэй.

Сургууль өөрийн онцлогт тохирсон дээрэлхэлтийн эсрэг журамтай болсон тохиолдолд сурагчид, эцэг эх, асран хамгаалагч, хүүхдийн амьдралд хамааралтай насанд хүрэгчид болон сургуулийн бүх шатны ажилчид зэрэг бүх субъектууд сургуулийн орчинд юу зохистой, юу зохисгүй үйлдэл болохыг, хүлээн зөвшөөршгүй үйлдэлд ямар арга хэмжээ авдгийг мэдэж авна

Дээрэлхэлтээс урьдчилан сэргийлэх үйл ажиллагаа нь бүх бага, дунд сургуулийн дээрэлхэлтийн эсрэг журмын үндсэн хэсэг байх ёстой.

Үр дүнтэй стратеги	Анхаарах зүйлс
Урьдчилан сэргийлэх, ойлголт нэмэгдүүлэх	Өөрийн үнэлэмж нь зан үйлийг тодорхойлох гол хүчин зүйл байдгийн хувьд сургууль нь хичээлийн ба хичээлээс гадуурх хөтөлбөрөөр дамжуулан сурагчдад өөрийнхөө талаар эерэг мэдрэмжийг бий болгох боломжийг бүрдүүлэх хэрэгтэй.
	Сурагчдын дээрэлхэлт, түүний учир шалтгаан, үр нөлөөний талаарх ойлголтыг нэмэгдүүлэхэд чиглэсэн санаачилга, хөтөлбөрүүд нь хувь хүний амин чанарт суурилсан дээрэлхэлтэд, ялангуяа тэр гомофобик ¹⁶ ба трансфобик ¹⁷ дээрэлхэлтийг тусгайлан авч үзэх хэрэгтэй. Жишээ нь, ЛГБТ зурагт хуудсыг мэдээллийн самбарт байршуулах, эцэг эхчүүдтэй сургуулийн ЛГБТ гишүүд найрсгаар хүлээж авах, хүндэтгэх гэсэн тодорхой мэдэгдэл оруулах тухай хэлэлцэх, нийгмийн, бие хүний, эрүүл мэндийн боловсролыг заах, ЛГБТ үйл ажиллагаанд оролцох гэх мэт нь гомофобик ба трансфобик дээрэлхэлтийн талаарх ойлголтыг нэмэгдүүлж болох зарим арга замууд юм.
	Урьдчилан сэргийлэх, ойлголтыг нэмэгдүүлэх арга хэмжээнд цахим дээрэлхэлтийг тусгайлан авч үзэх хэрэгтэй. Цахим дээрэлхэлтийг хөндөх хамгийн шилдэг арга бол ийм дээрэлхэлт болохоос өмнө урьдчилан сэргийлэх явдал. Урьдчилан сэргийлэх, ойлголт нэмэгдүүлэх арга зам нь сурагчдад онлайн орчин дахь зохистой зан үйлийн талаар боловсрол олгох, цахим ертөнцөд байхдаа хувийн аюулгүй байдлаа хамгаалах, мөн цахим дээрэлхэлттэй холбоотой асуудлыг мэдээлэх орчин бүрдүүлэхэд чиглэх хэрэгтэй.
	Дээрэлхэлтийг шийдвэрлэх, урьдчилан сэргийлэх сургуулийн арга зам, хандлага нь хөгжлийн бэрхшээлтэй, боловсролын ялгаатай хэрэгцээт хүүхдүүдийн хэрэгцээг бодолцох ёстой. Эдгээр сурагчдад үзүүлэх үйлчилгээ нь сургуулийн бусад журамд нэгтгэгдэх, тэдгээрийг дэмжих хэрэгтэй. Боловсролын ялгаатай хэрэгцээт сурагчдын дээрэлхүүлэх магадлалыг бууруулах арга зам нь оролцоог нэмэгдүүлэх, харилцааны чадварыг хөгжүүлэхэд төвлөрөх, бага ангиас дунд анги руу шилжих онцгой цаг үед анхаарал хандуулах, бүгдийг хүндэлдэг, бие биедээ тусалдаг сургуулийн эерэг соёлыг бүрдүүлэхэд анхаарах хэрэгтэй.

16

17 Гомофобик, трансфобик- ЛГБТИК+ олон нийтийг гадуурхах, үзэн ядах үзэл, хандлага

	<p>Сургуулийн урьдчилан сэргийлэх, ойлголтыг нэмэгдүүлэх арга хэмжээ нь дээрэлхэлтийн хэлбэр, оролцогч сурагчдын насны онцлогт тохирсон байх хэрэгтэй. Сургууль бүр дээрэлхэлтийн талаарх хамт олны ойлголтыг нэмэгдүүлж, тэгснээр сургуулийн бүх гишүүд дээрэлхэлт гэж юу болохыг ойлгож, дээрэлхүү зан үйлд ямар арга хэмжээ авдгийг мэддэг болоход чиглэн ажиллах ёстой</p> <p>Сургуулиуд дээрэлхэлтийн асуудлыг хөндөж, сургуулийн ажилтнуудад зориулсан, мөн сурагч, эцэг эх, асран хамгаалагчдад зориулсан өдөрлөг зохион байгуулж болно. Ийм ойлголтыг нэмэгдүүлэх өдөрлөг нь дээрэлхэлтэд өртөж буй хүүхдийн эцэг эх, асран хамгаалагч сургуультай хамтарч ажиллах итгэлийг өгөх ач холбогдолтой ба дээрэлхэлт үйлдэж буй хүүхдийн эцэг эх, асран хамгаалагч хүүхдийнхээ зан үйлийг засахад гол хариуцлага хүлээнэ гэдгийг тодорхой ойлгуулдаг.</p> <p>Багш нар дээрэлхүү зан үйлийн талаарх хандлагыг өөрсдийн заадаг хичээлийн болон бусад хөтөлбөрөөр дамжуулан эерэг байдлаар өөрчилж болно. Аль ч хичээлийг заах явцад бие биеэ хүндлэхийг заах боломжтой: олон янз байдлыг үнэлж, дэмжих; сөрөг хандлага, хэвшмэл үзлийг авч үзэж, дээрэлхүү зан үйл байж болохгүй гэдгийг тодотгох зэрэг. Иргэний боловсрол, нийгэм судлал зэрэг хүмүүсийн харилцан хамаарлыг орон нутаг, улс үндэстэн, олон улсын түвшинд тодруулан авч үздэг. Газарзүй, түүхийн хичээлээр эрх мэдлийн сөрөг талыг колоничлол, дарангуйллын жишээгээр харуулах боломжтой</p> <p>Хичээлээс гадуурх үйл ажиллагаагаар, тухайлбал, урлагийн боловсрол, багийн спорт, сургуулийн клуб, нийгэмлэгээр дамжуулан хамтран ажиллах, бүлгийн ажлыг дэмжин хөгжүүлэх боломжтой. Спортын үйл ажиллагаа нь тэр тусмаа түрэмгий занг хэрхэн хувиргаж, өөрчилж, хянах боломжийг олгодог.</p>
Асуудал үүсэхэд олон талт оролцоог хангаж ажиллах	<p>Жижүүр багшийн ээлж солигдох үеэр онцгойлон хяналт тавьж болно. Хамгийн их дээрэлхэлт явагдах нөхцөл бүрддэг “халуун цэг” болон “оргил цаг”-ийг олж тогтоох нь дээрэлхэлтийг зогсооход чухал ач холбогдолтой</p> <p>Бүх сурагчид, ялангуяа ахлах ангийн сурагчдыг дээрэлхэлтийн эсрэг тэмцэгчид болгон бэлтгэх нь тохиромжтой. Энэ тал дээр сурагчдын зөвлөл, мөн бусад клубүүд, нийгэмлэгүүд чухал нөлөө үзүүлж чадна. Сургуулийн бусад ажилтнууд ч бас сургуулийн орчны дээрэлхэлтийг зогсооход хувь нэмрээ оруулах ёстой. Тэгээд ч зогсохгүй бүх эцэг эхчүүдийг хамруулсан бүх талын стратеги, арга хэмжээг бас зохион байгуулах нь хэрэгтэй.</p>

Үр дүнтэй туршлагад дээрэлхэлтийн бүх хэлбэрийг, бүхий л орчинд урьдчилан сэргийлэх ба ойлголтыг нэмэгдүүлэх, асуудал үүсэхэд сурагчдыг оролцуулах стратеги ордог. Ялангуяа, эдгээр стратеги нь сурагчдын эмпати (бусдын оронд өөрийгөө тавьж үзэх), хүндлэл, зоригийг нэмэгдүүлэх хэрэгтэй.

6. ДЭЭРЭЛХЭЛТИЙГ ТАСЛАН ЗОГСООХ СТРАТЕГИ

Дээрэлхэлт болоход тухайн цаг үед нь маш тодорхой арга хэмжээг тогтмол авч хэрэгжүүлж байх нь үр дүнтэй ажиллагааны салшгүй хэсэг юм. Энэ хэсэгт сургуулийн орчинд гарч буй дээрэлхэлтийг таслан зогсоох стратеги боловсруулж, гарсан дээрэлхэлийн тохиолдол бүрийг тогтмол тэмдэглэн бүртгэл хөтлөх тухай заавар чиглэлийг өгөх болно.

Сургууль дээр дээрэлхэлтийн асуудлуудыг шалгаж, арга хэмжээ авах үүрэг хариуцлага хүлээсэн багш, ажилтан нь хэн бэ гэдгийг хүн бүр маш сайн мэддэг байх ёстой. Ихэнх ЕБС дээр сургуулийн нийгмийн ажилтан тус үүргийг гүйцэтгэдэг. Харин бага ангийн түвшинд хариуцах багш нь анги удирдсан багш өөрөө байвал үр дүнтэй. Сургуулийн дээрэлхэлтээс урьдчилан сэргийлэх журамд эдгээр багш нар хэн хэн болохыг тодорхой дурдсан байх ёстой. Сургуулийн орчинд дээрэлхэлтийг таслан зогсооход хэрэглэж болох олон хувилбарууд байдаг. Дээрэлхэлийн тохиолдлыг илрүүлэхэд төвөгтэй учраас бүгдэд нь тохирсон таслан зогсоох арга хэмжээ гэж байдаггүй. Дотоодын болон олон улсын судалгаагаар энэ асуудлыг үргэлжлүүлэн судалсаар байгаа бөгөөд тодорхой хариу арга хэмжээнүүд хэр үр дүнтэй байгааг ч судалсаар байна.

Тиймээс сургууль бүр өөр өөрийн одоогийн нөхцөл байдлаа харгалзан үзээд тохирох хамгийн сайн гэсэн арга барилыг сонгох нь зүйтэй бөгөөд сургуулийн бүх гишүүдэд дээрэлхэлтийн тохиолдолд ямар арга хэмжээ авах тухай ойлголт өгөхийн тулд ямар арга барилаар ажиллах ээргээ сургуулийн дээрэлхэлийн эсрэг журамд нарийвчлан тодорхойлсон байх ёстой.

Дээрэлхэлтийг илрүүлэх шийдвэрлэх үе шатууд

Сургуулийн захиргаанаас дээрэлхэлтийг илрүүлэх, шийдвэрлэх үе шатуудыг тодорхойлох бөгөөд тэдгээрийг сургуулийн захиргаанаас дээрэлхэлийн эсрэг журамдаа тусгаж өгвөл зохино. Сургуулийн дээрэлхэлийн үе шатуудад дараах хамаарна:

Үе шат	Хэрэгжүүлэх арга хэмжээ
1	Хариуцсан багш дээрэлхэлийг илрүүлэх, шийдвэрлэхдээ асуудлыг шийдвэрлээд асуудалд оролцсон хүүхдийг аль болох хэвийн харилцаанд нь буцаан оруулах (зэмлэж тусгаарлах гэж оролдолгүй) тал дээр голлон анхаарууштай;
2	Дээрэлхэлийг илрүүлэх, шийдвэрлэх явцдаа багш өөрийн мэргэжлийн ур чадвараа ашиглан энэ үнэхээр дээрэлхэл мөн үү, нөхцөл байдал хэрхэн хамгийн үр дүнтэйгээр шийдвэрлэгдэх вэ зэргийг шүүн тунгаах хэрэгтэй
3	Дээрэлхэлтийн тухай нэрээ нууцалсан мэдээлэл болон нэрээ нууцлаагүй мэдээллийн дагуу хариуцсан багш асуудлыг шийдвэрлэх ёстой. Ингэснээр сурагчид "хэлэх" нь үр дүнтэй юм байна гэсэн итгэлтэй болно. Итгэлийг нь олох нь маш чухал хүчин зүйл юм. Сурагчид үйл явдлыг мэдэгдэх нь хов зөөж буй хэрэг биш харин хариуцлагатай зан үйлд тооцогдохыг сурагчдад тодорхой ойлгуулах ёстой;
4	Багш бус ажилтнууд буюу нарийн бичиг, тусгай хэрэгцээт боловсролын мэргэжилтэн, автобусны жолооч, асрагч, цэвэрлэгчид хэрвээ дээрэлхэлийн тухай ямар нэгэн мэдээлэл авсан бол, эсвэл өөрөө харсан бол хариуцсан багшид мэдэгдэх ёстой;
5	Эцэг эх, асран хамгаалагч болон сурагчид сургуулиас дээрэлхэлийг илрүүлэхэд хамтран ажиллаж, тухайн үйл явдалд оролцсон талуудын харилцааг аль болох түргэн хугацаанд чадахаараа сайжруулахад нь туслах хэрэгтэй;
6	Оролцож байгаа бүх талууд (сурагчид, эцэг эх, асран хамгаалагчийг багтаагаад) дээр дурдсан үйл ажиллагааны зорилго, чигийг эхнээс нь ойлгосон байх нь маш чухал юм;
7	Багш нар дээрэлхэл боллоо гэсэн мэдээллийг сурагчид, ажилчид, эцэг эх, асран хамгаалагчаас авсан бол асуудлыг шийдэхдээ тайван, сэтгэл хөдлөлийн бус байдлаар хандах нь зүйтэй;
8	Дээрэлхэлийг илрүүлэхэд оролцож байгаа хүмүүсийнхээ мэдээллийг нууцлахад анги танхимын бус орчин илүү дээр
9	Яриа хийх бүрдээ оролцож буй бүх сурагчдын эрхийг бодолцон маш болгоомжтой ажиллавал зохино. Ингэснээр яг шууд оролцоогүй сурагчид ч бас хэрэгтэй мэдээлэл өгөх нөхцөл бүрдэнэ;
10	Хариуцсан багш дээрэлхэлийн нөхцөл байдалд анализ хийхдээ юу, хэн, хэзээ, хаана, яагаад гэсэн асуултуудад хариулт хайж байх ёстой. Ингэхдээ тайвнаар, зөрчил маргааныг ямар нэгэн түрэмгийлэлгүйгээр шийдэж болдгийг харуулж үлгэр жишээ болох ёстой;
11	Хэрвээ бүлгээр үйлдсэн дээрэлхэлийн асуудал бол эхлээд оролцсон хүүхэд бүрийг нэг нэгээр нь ярилцлагад оруулна. Түүний дараагаар бүх оролцсон хүмүүсийг бүлгээр авч уулзах ёстой. Бүлгээр уулзаж байгаа үед хүн болгоноос юу болсон тухай асууснаар бүлгийн гишүүд бүгд бие биенийхээ мэдүүлгийг тодорхой ойлгоно;
12	Ярилцлагын дараа бүх оролцсон гишүүдийн эсрэг бүлгээс ирж болзошгүй дарамтыг шийдвэрлэхэд туслах ёстой;
13	Оролцсон хүүхдүүдээр болсон явдлын тухай бичүүлж авах нь давуу талтай ч байж болох юм;
14	Хэрвээ хариуцсан багш дээрэлхэл болсон гэж үзвэл дээрэлхэлийн явцад оролцсон болон өртсөн хүүхдүүдийн эцэг эх гэр бүлийн гишүүд рүү холбогдож ямар арга хэмжээ авах гэж байгаагаа мэдэгдэх ёстой (сургуулийн журамд заасны дагуу), Мөн сургууль авч байгаа арга хэмжээний талаар мөн сурагчдаа дэмжих тал дээр эцэг эх, асран хамгаалагчийн саналыг сонсвол зохилтой.

15	Хэрвээ хариуцсан багш нь сурагчаа хэн нэгнийг дээрэлхлээ гэж үзвэл тухайн сурагчид сургуулийн дээрэлхэлтийн эсрэг журмыг зөрчиж байгааг ойлгуулж, дээрэлхүүлж байгаа хүүхдийн өнцгөөс юмсыг харуулах гэж хичээх хэрэгтэй
16	Ямар нэгэн хариуцлага тооцох шаардлагатай нөхцөл үүслээ гэхэд тэр нь хариуцлага тооцуулж байгаа хүүхэд, түүний эцэг эх, асран хамгаалагч болон сургуулийн хоорондын хувийн асуудал юм гэдгийг бүх оролцогч талуудад (сурагчид болон эцэг эх, асран хамгаалагч) мэдээлэх ёстой;
17	Оролцогч талуудтай уулзахдаа дээрэлхүүлсэн хүүхэд бэлэн бөгөөд зөвшөөрвөл хожим бүх талуудтай хамт уулзана гэсэн өнцгөөс хандах хэрэгтэй;
18	Хэрвээ хариуцсан багш дээрэлхэл болсон гэж үзсэнээс хойш хичээлийн 20 хоногийн дотор дээрэлхэгчийн зан үйлдэлд засарсан байдал ажиглагдахгүй байвал хариуцсан багш энэ тухай Хавсралт 3-т оруулсан загвар дээр тэмдэглэн үлдээнэ;
19	Дээрэлхэлтийн зан үйлдэл засарсан эсэхийг тодорхойлохын тулд багш мэргэжлийн ур чадвараа ашиглан дараах хүчин зүйлүүдийг тооцон авч үзэх хэрэгтэй. Дээрэлхэл зогссон эсэх <ul style="list-style-type: none"> • Талууд хоорондын асуудал шийдэж болох хэмжээнд шийдэгдсэн эсэх; • Талууд хоорондын харилцаа аль болох сайжирсан эсэх; • Оролцсон бүх талууд болон тэдгээрийн эцэг эх, асран хамгаалагч эсвэл сургуулийн захирлын нөхцөл байдалд өгсөн хариу;
20	Хэрвээ эцэг эх, асран хамгаалагч дээрэлхэлийн асуудал шийдэгдсэн байдалд сэтгэл ханамжгүй байвал сургуулийн дүрэмд байгаа гомдол гаргах үе шатуудыг зааж өгөх ёстой;
21	Хэрвээ эцэг эх, асран хамгаалагч сургуулийн гомдол мэдүүлэх үйл ажиллагааны үе шатуудын дагуу гомдол мэдүүлсэн хэдий ч сэтгэл ханамжгүй байвал сургуулийн зүгээс эцэг эх, асран хамгаалагчид хүүхэд хамгаалалын байгууллагад гомдол гаргах эрхтэй гэдгийг зөвлөх ёстой.

7. НОТолгоонд суурилсан хариу арга хэмжээний тактикууд

Дээрэлхэлтийн тохиолдлыг тэмдэглэж бүртгэх

Сургуулийн зөвлөл нь сургуулийн дээрэлхэлтийн эсрэг журамд дээрэлхэлтийн тэмдэглэл бүртгэл хэрхэн хөтлөхийг заасан эсэхийг нягталж, тэмдэглэл нь хувь хүний мэдээлэл хамгаалах зохицуулалтын дагуу хадгалагдах ёстой. Сургуулийн дээрэлхэлийг тэмдэглэх, мэдээлэх үйл явц нь дараах байдлаар өрнөх ёстой.

1. Дээрэлхэлийн талаар ирж байгаа бүх мэдүүлэг, мэдээлэл түүнчлэн нэр нь нууцлагдсан мэдүүлэгүүдийг ч хариуцсан багш анхааралтай хянан шалгаж, бүртгэлд оруулна. Ямар арга хэмжээ авснаа бүртгэлд оруулан мөн адил хэрэг гарсан тохиолдолд хэлэлцүүлэгт оролцоно.
2. Хэрвээ хариуцсан багш дээрэлхэлт болсон гэж үзвэл тухайн явдлын тухай тэмдэглэл хөтлөх ёстой бөгөөд тэр нь цаашдаа тус асуудлыг шийдвэрлэж, талуудын харилцааг сэргээхэд нь тус дөхөм болох юм.
3. Хариуцсан багш дараах нөхцлүүдэд Хавсралт 1 (Дээрэлхэлтийн зан үйлийг бүртгэх, тэмдэглэх хуудас)–т оруулсан загварыг ашиглан дээрэлхэлтийн тухай тэмдэглэл хийж бүртгэлд оруулах ёстой.

а) Хэрвээ хариуцсан багш (нийгмийн ажилтан) дээрэлхэлт болсон гэж үзсэнээс хойш хичээлийн 20 хоногийн дотор дээрэлхэгчийн зан үйлдэлд засарсан шинж байдал ажиглагдахгүй байвал,

б) Сургуулийн дээрэлхэлтийн эсрэг журамд тодорхой нөхцөл заасан дээрэлхэлтийн зан үйлийг бүртгэж, нэн даруй сургуулийн захиралд шууд мэдэгдэх ёстой гэж тусгасан үед.

Дээр дурдсан (а) болон (б) нөхцөлүүдэд Хавсралт 3-ын загварыг хариуцсан багш бүрэн

гүйцэд бөглөн хадгалах бөгөөд хуулбарыг сургуулийн захиргаанд хүртээмжтэй байдлаар архивлана. Мөн дээрэлхэлтийн тэмдэглэл нь цаг хугацааны хувьд хэдий эрт ч байлаа гэсэн хариуцсан багш сургуулийн захиргаатай зөвлөлдөх эрхтэй.

Дээрэлхэлт нь даамжирсан зан авирын нэг хэсэг байх үед яах вэ?

Ноцтой кэйсүүдийг хүүхэд, гэр бүл, нийгмийн үйлчилгээний төрийн байгууллагад шилжүүлэх тухай

1. Хэрвээ тухайн тохиолдол ноцтой бөгөөд дээрэлхэгчийн зан үйл нь хүчирхийллийн шинжтэй бол тухайн сургууль хүүхэд, гэр бүл, нийгмийн үйлчилгээний асуудал хариуцсан төрийн байгууллагатай холбогдож тохирох хариу арга хэмжээний төлөвлөгөө боловсруулах ёстой.
2. Хүүхэд нэгдүгээрт зарчмыг баримтлахын сацуу Хүүхэд хамгааллын болон Хүүхдийн эрхийн хуулиудад заасны дагуу дээрэлхэлийн ноцтой зан үйлийн тохиолдлуудыг хүүхэд, гэр бүл, нийгмийн үйлчилгээний төрийн байгууллага руу шилжүүлнэ.
3. Хэрвээ тухайн сургуулийн багш дээрэлхэгч зан үйлтэй хүүхдийн асуудлыг цааш (төрийн байгууллага) мэдэгдэх эсэхэд эргэлзэж байвал тухайн байгууллагуудаас зөвлөгөө авах ёстой.

Үе тэнгийн дээрэлхэлт нь нэг удаагийн хэрэг бус даамжирсан сөрөг зан авирын нэгээхэн хэсэг байж болох бөгөөд зарим үед сургууль, багшийн үе тэнгийн дээрэлхэлт гэж үзэж буй асуудлаас даамжирсан ноцтой, бие махбодын эсвэл бэлгийн халдлага, хүчирхийлэл ч байж болзошгүй байдаг. Дээрэлхэлтийн тохиолдлуудад зүй зохистой арга хэмжээ авч байхын тулд сургуулийн дээрэлхэлтийн эсрэг журамд ямар үед ямар арга хэмжээ авч байх талаар ерөнхийлсөн зан суртахууны жишиг гаргах чухал. Мөн бусад оролцогчдод (цагдаа, дэлгүүрийн худалдагч, хүүхэд хамгааллын ажилтан гэх мэт) ямар зөвлөмж өгөх тухай тодорхой заасан байх ёстой. Сурагчийн зан авирын асуудал хэтэрхий ноцтой байх үед гэр бүл, хүүхдийн асуудал төрийн захиргааны байгууллага, сэтгэл зүйн чиглэлээр мэргэшсэн байгууллагуудад хандаж зөвлөгөө хүсэх хэрэгтэй.

Дээрэлхүүлсэн сурагчдад үзүүлэх дэмжлэг

Журманд дээрэлхүүлсэн сурагчдад үзүүлэх нийгэм-сэтгэл зүйн дэмжлэгийн хөтөлбөр гэж байх ёстой. Ийм асуудалтай нүүр тулсан сурагчдад сэтгэл зүйн зөвлөгөө, эсвэл тэдний өөрийгөө үнэлэх үнэлэмжийг нэмэгдүүлэх, нөхөрлөл болон нийгмийн харилцааг нь сайжруулан тэдний сэтгэлийг сэргээх үйл ажиллагаануудад хамрагдах боломж олгох хэрэгтэй байдаг. Дээрэлхүүлсэн сурагчийг дэмжих хөтөлбөр нь сургуулийн дээрэлхэлтийг таслан зогсоох, мэдээлэх үйл явцын нэгээхэн хэсэг. Дээрэлхэлтэд өртсөн хүүхдэд асуудлыг нь шийдвэрлэж өгөхөөс гадна цааш үргэлжлүүлсэн тусламж, дэмжлэг хэрэгтэй байдаг. Учир нь өөрийгөө үнэлэх үнэлэмж доогуур сурагчдад өөрийн үнэ цэнийн мэдрэмжийг дээшлүүлэх боломжуудыг нэмэгдүүлэх хэрэгтэй. Иймээс сургуулийн авч хэрэгжүүлж буй сургалтын хөтөлбөрүүд ч бас сурагчийн өөрийн үнэлэмжийг нэмэгдүүлэхүйц байх нь чухал.

Дээрэлхэлтийг ажигласан, гэрч болсон сурагчдад энэ тухайгаа багштайгаа ярих, мэдээлэл өгөхийг нь дэмжих ёстой.

Дээрэлхэлтийн эсрэг журмын үр дүнтэй байдлыг үнэлэх нь

Сургуулийн дээрэлхэлтийн эсрэг журам үр дүнтэй байгаа эсэх нь тулгарч буй дээрэлхэлттэй холбоотой асуудлууд хэрхэн шийдэгдэж байгаагаас харагдана. Сургууль нь дээрэлхэлтээс сэргийлэх болон таслан зогсоох стратегиуд нь үр нөлөөтэй байгаа эсэхийг тодорхой мөчлөгтэйгөөр шалгаж байх хэрэгтэй. Хэрвээ ном журмынх нь дагуу авч чадвал сурагчид болон

эцэг эхчүүдээс авсан судалгаа нь дээрэлхэлтийн эсрэг арга хэмжээнүүд хэр зэрэг үр дүнтэй байгаа тухай хэрэгтэй мэдээлэл өгөхөөс гадна зан авирын чиг хандлагыг олж тогтоосноор урьдаас сэргийлэхэд хэрэг болж болох юм.

Хавсралт 1—т оруулсан дээрэлхэлтийн бүртгэл тэмдэглэлийн загвар хуудас нь сургуульд болж байгаа дээрэлхэлтийн тухай тэмдэглэхэд маш үр дүнтэй бөгөөд хэрэглэхэд хялбар нөөц болж өгдөг. Цуглуулсан мэдээллийг/датаг тогтмол (дор хаяж жилд нэг удаа) дээрэлхэлтийн түвшинг тогтоох болон ямар нэгэн анхаарууштай нийтлэг чиг хандлага бүхий зан авирын илрэлүүд байгаа эсэхийг нягтлан үзэх зорилготойгоор цэгцлэн, дүн шинжилгээ хийх хэрэгтэй.

Дээрэлхэлтийн эсрэг журмын хяналт, үнэлгээ

Дээрэлхэлийн эсрэг журмын хэрэгжилт болон үр дүнг багш, ажилчдын хурлын хэлэлцэх асуудлаар оруулах ингэснээр журам болон сурагч бүрийн аюулгүй байдал ямар байгаа талаар үр дүнтэй хэлэлцэгдэх боломжтой болно. Үүнд дараах байдлаар хяналт хийж болно.

1. Сургуулийн зөвлөлд улирлаар өгөх хураангуй тайлан

Сургуулийн захирал хичээлийн жилийн улирал бүр сургуулийн зөвлөлд дараах зүйлсийг тайлагнах ёстой. Үүнд:

- I. Өмнөх удаагийн тайлангаас хойш хүлээн авсан бүх дээрэлхэлтийн мэдээллийн (хавсралт 1-ын дагуу) тоо хэмжээ.
- II. Хэсэгт дурдсан бүх мэдээллийн мөрөөр сургуулийн дээрэлхэлтийн эсрэг журмын үе шатуудын дагуу бага, дунд, ахлах ангийн түвшинд авч хэрэгжүүлсэн арга хэмжээ эсвэл авч хэрэгжүүлж буй арга хэмжээ байгааг батлах баталгаа, нотолгоо.



Анхаарах зүйл. Сургуулийн зөвлөлийн хурлын тэмдэглэлд дээр дурдсан зүйлсийг тэмдэглэх ёстой, тэгэхдээ оролцсон хүүхдүүдийн нэрийг дурдахгүй байх нь зүйтэй.

2. Удирдах зөвлөлийн жил бүрийн хяналт

Сургуулийн захиргаа сургуулийнхаа дээрэлхэлтийн журмыг болон түүний хэрэгжилтийг жил бүр хянан шалгаж байх ёстой.

Тэдгээр үйл явцуудыг шалгах хуудас Хавсралт 2 (Дээрэлхэлийн эсрэг журмын хэрэгжилт болон биелэлтийг шалгах асуулга) бөгөөд сургуулийн дээрэлхэлийн эсрэг журмын өөр өөр элементүүд дэх хэрэгжилтийг зохистойгоор шинжлэхийн тулд шалгах хуудсандаа заавал тоон болон чанарын шинжилгээ хийх ёстой. Үүнд нэн түрүүнд сургуулийн зүгээс хяналт шалгалтаар сайжруулах шаардлагатай гэж үзсэн сургуулийн гадаад, дотоод орчинд зориулсан үйл ажиллагааны төлөвлөгөөг боловсруулах ёстой

Хяналт шалгалт дууссан үед үр дүнгийн тухай сургуулийн багш, ажилчдад мэдэгдэх, сургуулийн цахим хуудсанд байрлуулах (хэрвээ цахим хуудас байхгүй бол сурагчид авахыг хүссэн үед ойр хүртээмжтэйгээр байрлуулах), мөн эцэг эхийн зөвлөлд өгөх хэрэгтэй (хэрвээ байдаг бол).

Ийм мэдэгдэл хийхэд зориулан стандартчилсан Хавсралт 3 (Удирдах Зөвлөлийн дээрэлхэлийн эсрэг журамд хийсэн хяналтын жилийн тойм)-т байгаа мэдэгдэх хуудсыг ашиглавал зохино. Хяналтын тэмдэглэл эсвэл үр дүн нь хариуцсан Яамнаас хүсэхэд бэлэн бөгөөд хэзээд өгөх боломжтой байх ёстой.

СУРГУУЛИЙН ОРЧИНД ХЭРЭГЖҮҮЛЖ БОЛОХУЙЦ ПРАКТИК ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЧИГЛЭЛ

Үе тэнгийн дээрэлхэлт сургуулийн бүхий л хамт олны санаа тавих ёстой асуудал бөгөөд эерэг найрсаг уур амьсгалтай, хүний эрх эрхэм чанарыг дээдлэн, ялгаатай байдлыг хүндэтгэсэн орчин бий болгох нь бүх хүний зорилго билээ. Бид энэ хэсэгт сургуулийн орчинд хэрэгжүүлж болох үйл ажиллагаа зохион байгуулахад дэмжлэг үзүүлэх, арга зүй олгох зорилготой бөгөөд үе тэнгийн дээрэлхэлт, дарамтын эсрэг аливаа үйл ажиллагаа зохион байгуулахыг хүссэн хүн бүр ашиглах боломжтой билээ.

1. СУРГУУЛЬ ДЭЭРЭЭ КАМПАНИТ АЖИЛ ЗОХИОН БАЙГУУЛАХ 5 АЛХАМ

Нэгдүгээр алхам: Зорилгоо тодорхойл

Үүнд: Үе тэнгийн дээрэлхэлт, дарамтын эсрэг түүнээс урьдчилан сэргийлэх ажлыг яагаад зохион байгуулах гэж байгаагаа тодорхойлж, ярилцаад зорилгоо тодорхойлно.

Жишээ нь:

- Үе тэнгийн дээрэлхэлт дарамтаас шалтгаалан хүүхдүүдэд сэтгэл санаагаар унах, ганцаардах, өвдөх, сургуулиа орхих, амиа хорлох зэрэг маш олон эрсдэл, аюул тулгардаг учраас хүүхдүүдийн дундах үе тэнгийн дээрэлхэлт дарамтыг таслан зогсоох зорилготой.
- Үе тэнгийн дээрэлхэлт дарамт нь хүчирхийллийн төрөл бөгөөд хүний эрхийг зөрчдөг мөн хүүхэд, сургуулийн багш ажилтнууд, гэр бүл, нийгэм зэрэг олон талд нөлөөлөх хор хохирлыг бий болгодог учраас үе тэнгийн дээрэлхэлт дарамтын талаар мэдлэг ойлголт олгож, урьдчилан сэргийлэх зорилготой гэх мэт

Мөн зорилтот бүлгээ нарийн тодруулах хэрэгтэй. Энэхүү үйл ажиллагааг хэнд зориулан, хаана хандаж хийхийг хүсч байгаагаа тодорхойлно. Зорилтот бүлгээ тодорхойлсноор хийх үйл ажиллагаа болон үр дүн тодорхой болох ач холбогдолтой.

Жишээ нь:

- Ахлах ангийн сурагчид
- Бага ангийн сурагчид
- Сургуулийн нийт багш ажилтнууд, эцэг эх, асран хамгаалагч, гэр бүлийн гишүүдэд гэх мэт

Хоёрдугаар алхам: Хүрэх үр дүнгээ тодорхойл

Хүлээгдэж буй үр дүнгээ тодорхойлох нь хийх ажил нь ямар ач холбогдолтойг илтгэн харуулахаас гадна, хийх ажлын амжилтыг ч илтгэх боломжтой юм.

Жишээ нь:

- Үе тэнгийн дээрэлхэлт, дарамтын талаарх ойлголт мэдлэгийг нэмэгдүүлнэ. Сард 1 удаа ямар нэг хэлбэрээр сурагчдад мэдээлэл өгнө.
- Сурагчдын дунд үе тэнгийн дээрэлхэлт, дарамтын талаарх мэдлэг ойлголт сайжирч мэдээлдэг/таслан зогсоодог болно.
- Сургуулийн орчинд хүн бүр урьдчилан сэргийлэх ажилд идэвхтэй оролцдог болно гэх мэт.

Гуравдугаар алхам: Үйл ажиллагаагаа сайтар төлөвлө


Үйл ажиллагааны төлөвлөгөө гаргах загвар

Ямар үйл ажиллагааг хэдий хугацаанд хийх мөн аль үйл ажиллагааг хэн хариуцах зэргийг нарийн төлөвлөх нь ажлыг амжилттай хэрэгжүүлэх чухал ач холбогдолтой. Жишээ нь:

№	Ерөнхий үйл ажиллагаа	Нарийвчилсан үйл ажиллагаа	Хугацаа	Хариуцах хүн
1.	Асуудал хуваалцах найз бий болгох	Хүүхдүүд бүртгэх	2020 оны 11 сарын 5	Хулан
		Асуудал хуваалцах найзыг бэлтгэх сургалт	2020 оны 11 сарын 9	Тамир

Дөрөвдүгээр алхам: Хамтрагчид татан оролцуул

Сургуулийн орчныг ээлтэй болгоход сурагчид болон багш нарын оролцоо хангалтгүй. Гэр бүлийн гишүүд, багш, сургуулийн удирдлага, бүх ажилтнууд хамтарч байж бүх хүүхдэд ээлтэй, аюулгүй орчин бүрдэх билээ. Мөн хүүхэд хамгааллын баг, хорооны нийгмийн ажилтан, гэр бүл хүүхэд залуучуудын асуудал хариуцсан төрийн байгууллага, цагдаа зэрэг сургуулийн гадна байдаг байгууллагуудыг татан оролцуулж болно.



Тавдугаар алхам: Мэдээллийн сувгуудыг ашигла

Сургуулийн нэгдсэн сайт, орон нутгийн хэвлэл мэдээллийн хэрэгсэл эвсэл фейсбүүк групп нээх, байдаг эсэхийг нь судлаад тухайн группын идэвхтэй гишүүдтэй уулзалт хийж цахим орчин дахь соёлын талаар ярилцаж болох юм. Цаашид сургуульдаа найрсаг, эерэг орчныг бий болгохын тулд тухайн группыг яаж идэвхжүүлэх вэ, ямар мэдээлэл хэрхэн цацах вэ, ямар дүрэм журамтай байх талаар ярилцах боломжтой. Сургуулийн групп эсвэл хуудсаас хэн нэгнийг илт муулсан, доромжилсон постыг шууд устгах, эерэг мэдээлэл 7 хоногт 1 удаа хуваалцаж байх гэх мэт өөрсдийн төлөвлөгөө гаргаарай. Мөн группын гишүүд оролцох нь илүү чухал учраас сэтгэгдэл бичихүйц асуулттай пост байвал үр дүнтэй.

Жишээ нь: Хамгийн сүүлд хэнд баярласан бэ? Бусадтайгаа хуваалцаарай. Ямар хичээл хамгийн сонирхолтой вэ? Яагаад?

Мөн хүүхдүүд бие биенээ илүү ойлгодог болоход хэрэгтэй, сэтгэл хөдөлгөм хэлэлцүүлэг өрнүүлж болно. Жишээ нь: Сүүлд хэзээ хэн нэгэнд гомдсон бэ? Яагаад? Хэн нэгэнд хэлж чадахгүй үгсээ хэлээрэй. гэх мэт



Анхаарах зүйлс:

1. Үйл ажиллагааны өнгө төрх бий болгох – Өнгөлөг, хүүхдүүдийн анхаарлыг татахуйц эерэг дүрслэлтэй байх – (хүүхдүүд өөрсдөө зурж, хийж болно)
2. Үйл ажиллагааны уриа, мессэж үгтэй байх- Зогс - Өөрийнхөө төлөө ЗОГС, Найзынхаа төлөө ЗОГС, Шоолохоосоо өмнө ЗОГС, ЧУХАЛ- Чи чухал, чиний найз
3. чухал, чиний үйлдэл чухал гэх мэт хүчтэй, шууд агуулга өгөх нь чухал.
4. Хүний эрхийн мэдрэмжтэй байх- Үйл ажиллагаа зохион байгуулахдаа хэнийг ч ялгаварлан гадуурхахгүй байх, үзэл бодлыг нь хүндэтгэх, шоолохгүй, доромжлохгүй, буруутгахгүй байх гэх мэт
5. Хүн бүрийн ялгаатай байдлыг харгалзан үзэх- Шинээр шилжиж ирсэн, ойрхон эсвэл хол гэртэй, хөгжлийн бэрхшээлтэй, ЛГБТИК+, зэрэг маш олон өөр ялгаатай хүмүүс нийгэмд, сургуульд чинь байгаа тул түүнийг ойлгож хүлээн зөвшөөрөх
6. Анхан шатны тусламж олгох мэдлэгтэй байх- Үйл ажиллагааны үеэр хэн нэгэн дээрэлхэлтэд өртсөн хувийн нууцаа эсвэл сэтгэлзүйн асуудлаа хуваалцаж, ил гаргаж болох юм. Тийм үед хэрхэн ажиллах төлөвлөгөөтэй байгаарай.

Зохион байгуулж буй үйл ажиллагааныхаа талаар маш сайн мэдлэг ойлголттой байх хэрэгтэй бөгөөд яаралтай тохиолдолд хаана хандах гэх зэрэг мэдлэгтэй байх нь чухал.

2. ЗОХИОН БАЙГУУЛЖ БОЛОХ ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ХУВИЛБАРУУД

Энэхүү үйл ажиллагаанууд нь санал болгож буй хувилбар бөгөөд сургуулийнхаа болон орон нутгийнхаа онцлогт тохируулан хэд хэдээр эсвэл дангаар нь сонгон зохион байгуулах боломжтой.

№	Үйл ажиллагааны нэр	Зохион байгуулалтын хэлбэр	Давуу тал
1	Асуудал хуваалцах найз	<p>Элсүүлэлт: Асуудал Хуваалцах Найз болохын тулд хүүхдүүд өргөдлийн маягт бөглөж, яагаад энэ ажлыг хийхийг хүсч байгаагаа ярилцлагын шатанд тайлбарлаж байлаа. Хэсэг бүлэг хүүхдүүд нэгдэж оролцохыг хүсч байв. Учир нь тэд өмнө жил асуудалтай байсан бөгөөд тэд шаардлагатай тусламжийг авсан учраас эргээд бусдад туслахыг хүссэн юм.</p> <p>Сургалт: Хүүхдүүд ярилцлага өгсний дараа 2 өдрийн сургалтад хамрагдсан. Өөрсдийн үүргээ бахархалтайгаар гүйцэтгэхдээ юу хийж болох, юуг хийж болохгүй зэрэг өөрсдийн хэмжээ хязгаарыг сайтар ойлгносоо илэрхийлсэн. Сургалт тэдэнд хэзээ асуудлыг багш ажилчдад дамжуулан хүргэх болон бусад чадваруудаа хэзээ хөгжүүлэх хэрэгтэйг зааж өгсөн.</p> <p>Өдөр бүр хийх ажил: Асуудлаа хуваалцах найзууд жижүүрийн хуваарийн дагуу тоглоомын талбайд элжлэн ажиллаж тоглоомын талбайг ажиглаж байсан. Хүүхдүүд уулзалтын цаг авч санаа зовж байгаа зүйлсийнхээ талаар Солонгон өрөөнд ярьж Асуудлаа хуваалцах найз нь тэднийг сонсож шийдлээ олоход нь тусалж байлаа.</p> <p>Хяналт: Тэд мөн хяналтын системтэй байсан, хэрвээ тухай нэг хүүхэд зургаагаас дээш удаа хандвал шууд хариуцсан багш руу шууд шилжүүлдэг байсан.</p>	<p>Сургууль бүр өөрсдийн хэрэгцээ шаардлагадаа нийцүүлж Асуудлаа хуваалцах найз, Солонгон цагдаа, Нөхөрлөлийн салаа, Үе тэнгийн зөвлөгч гэх мэт нэршлийн дор эдгээр бүлгүүд үе тэнгийнхнээ сонсож дэмжих дэмжлэгийг өгдөг. Эдгээр бүлгүүдэд тэдний үүрэг хариуцлагын талаар сургалт хийж чадавхжуулдаг бөгөөд эдгээр бүлгүүдийг дэмжин ажиллах ажилтан томилдог.</p>
2	Санаа зовнилын хайрцаг	<p>Хүүхдүүд санаа зовоосон асуудлаа цаасан дээр бичээд хайрцагт хийнэ. Хүсвэл нэрээ бичихгүй байж болно. Багш нар энэхүү хайрцагт тогтмол хяналт тавьж хүүхдүүдтэйгээ ганцаарчлан уулзах буюу эсвэл ангиараа тойрон сууж ярилцах цагаар асуудлыг хэлэлцүүлнэ.</p>	<p>Хэрвээ чи айдастай байгаа бол санаа зовнилын хайрцгийг ашиглаж болно” “Хэрвээ чи санаа зовнисон байвал багш чамтай ганцаарчлан уулзаж, чиний асуудалд маш анхааралтай хандана” “</p>



3	Тойрог уулзалтын цаг	Аюулгүйн дүрмийг баримталсан тогтмол уулзалтыг хэлнэ. Тойрог уулзалтын зорилго нь янз бүр байж болох бөгөөд тухайлбал, том асуудлыг дэвшүүлэн өргөнөөр хэлэлцэх, өөрсдийн мэдрэмжээ айлгүй илэрхийлэх, хэлэлцэх; нийгэмших чадвараа загварчлах, хөгжүүлэх; анги хамт олны харилцааг хөгжүүлэх зэрэг.	Тойрог уулзалтын цаг хамгийн түгээмэл сонстолын тогтолцоо бөгөөд сурагчид агуулгыг өөрсдөө хөтөлж авч явах боломжийг олгодог байна. Санал асуулгын хуудас нь сурагчдад тулгарч байгаа хүүхэд хамгааллын асуудалд анхаарч дээрэлхэлийн асуудлыг үр дүнтэй шийдвэрлэх зөвлөмж бүхий арга замууд руу сургуулиудыг чиглүүлсэн.
4	Дэмжлэгийн бүлгүүд	6-10 хүүхдүүдээс бүрдсэн жижиг бүлэг / сургуульд суурилсан залуу хүмүүс байх бөгөөд сургалтад хамрагдсан томчууд энэхүү бүлэгт ажиллана. Дэмжлэгийн бүлэг нь богино хугацааны, тодорхой бүлэгт чиглэсэн, урьдчилан сэргийлэх стратегийг баримтална. Энэхүү стратеги нь нийгмийн, сэтгэл хөдлөлийн, зан үйлийн бэрхшээлээс үүдэн суралцахуйн бэрхшээлтэй нүүр тулгарч буй сурагчид руу чиглэсэн, бүх сурагчдыг хамарсан, дэмжсэн арга барилаар ажиллана. Өөрөөр хэлбэл бүлгээр ажиллах үйл ажиллагаанд сурагчдын нийгэмших чадварыг хөгжүүлнэ. Үр дүнд хүрэхийн тулд чадварлаг мэргэжилтнүүдийн янз бүрийн арга техник ашиглаж хүүхдүүдийг дахин анги хамт олонтойгоо нийлэхэд нь тусалдаг.	Дэмжлэгийн тогтолцоо нь аль болох эрт үед нь асуудлыг танин мэдэж хариу арга хэмжээ авах мөн хүчирхийлэлд өртөх эрсдэлтэй эсхүл анхаарлын гадна үлдэх магадлалтай бүлгийн сурагчдад тухайн цаг үед нь тохирсон арга хэмжээг авах бүтэц зохион байгуулалтай байдаг.
5	Үдийн цай болон өглөөний цайны клуб	Албан бус уулзалтын хэлбэр бөгөөд хэрэв хүсвэл хүүхдүүд энэхүү боломжийг ашиглан асуудлаа ярьж болно. Нэгэн сургууль үдийн цайны дэмжлэгийн бүлэгтэй бөгөөд хэрвээ хүүхдүүдэд дэмжлэг хэрэгтэй байвал энэхүү бүлэгт хандаж болдог.	Үе тэнгийн дэмжлэгийн тогтолцоо нь хүүхдүүд бие биедээ туслахыг хөхүүлэн дэмжсэн зохистой нөөц бололцоотой мөн маш сайн дэмжлэгтэй байна.
6	Ганцаарчилсан зөвлөгөө	Сайн дурын байгууллагууд эсхүл орон нутгийн төрийн үйлчилгээний байгууллагаас тусалцаа авч энэхүү үйлчилгээг сурагчдад үзүүлж болно. Хүүхдүүдийн санаа зовж буй асуудал нь өөртэй нь хамаатай, эцэг эхэд хамаарах, эсвэл багш ажилчдад хамаарах асуудал байж болно.	Төрөл бүрийн дэмжлэгийн тогтолцоонууд нь бүхэлдээ стратегийн нэгэн хэсэг болох бөгөөд бие биенээ харилцан нөхсөн зохицуулалттай байна. Түүнчлэн сургуулиас үзүүлэх дэмжлэгийн нэгээхэн хэсэгт нь ганцаарчилсан дэмжлэг мөн багтана.
7	Найзуудын тойрог	Энэхүү бүлэг нь асуудалтай сурагчдыг дэмжихэд оршино. "Найзуудын тойрог" нь бүгдийг тэгш хамруулсан, тэгш оролцоог хангасан буюу сургууль дээрээ хөгжлийн бэрхшээлээс болоод, хувийн чанартай асуудлаасаа болоод эсхүл бусдад эрсдэлтэй зан үйл гаргаснаасаа болоод гадуурхагддаг хэн бүхнийг хамруулан оролцуулна	
8	Найзууд	Шинэ сурагч шилжин ирэхэд тэднийг дасан зохицоход нь туслах найзын тогтолцоотой байдаг. Энэ тогтолцоо нь маргинал бүлгийн сурагчдад мөн адил тусалдаг.	

3. БАГШ НАР ЮУ ХИЙЖ ЧАДАХ ВЭ?

Үе тэнгийн дээрэлхэлт, хүүхдүүдийн дунд үйлдэгддэг аливаа хүчирхийллийг таслан зогсоох, сургууль дээрх эрүүл, аюулгүй орчин бүрдүүлэхэд ангийн багш, сургуулийн багш, сурган хүмүүжүүлэгчид маш том нөлөөтэй чухал хүмүүс билээ. Танай сургууль “үе тэнгийн дээрэлхэлтийн эсрэг журам”-гүй бол бид нэг хүүхдийн ч гэсэн өдөр тутмын амьдрал, суралцах орчин нөхцөлийг айдасгүй, амар амгалан болгоход тань туслах дараах хэдэн аргуудаас бүхэндээ хуваалцаж байна.

Дээрэлхэлтийн нөхцөл байдлыг илрүүлэх арга

“Хэрвээ чи санаа зовнисон байвал багш чамтай ганцаарчилан уулзаж, чиний асуудалд маш анхааралтай хандана”

“Санаа зовинолын хайрцаг бол “хэрвээ чи айдастай байгаа бол санаа зовинолын хайрцагыг ашиглаж болно” гэсэн үг”

(Фокус бүлгийн ярилцалгын үеэр хүүхдийн хэлсэн үг)

Аливаа өөрчлөлтийг бий болгоход тухайн бүлгийн хүн бүхэн оролцож, өөрсдийн дуу хоолойгоо илэрхийлж байх нь маш чухал юм. Тиймээс сурагч бүрийг оролцуулж, дуу цөөтэй хүүхдүүдийг тэр тусмаа бусдад үзэл бодлоо илэрхийлэхэд нь дэмжлэг үзүүлээрэй. Мөн хэн нэгний төлөө дуугарч байгаа сурагч бүрээ урамшуулж, сайхан үг хэлж байх чухал.

ҮЙЛ АЖИЛЛАГАА 1


Санаа зовнилын хайрцаг

Бэлдэх зүйлс:

- Цоожтой хайрцаг
- Зарлалын самбар

Хийх зүйлс:

1. Сургуулийн хүн бага очдог газар санаа зовнилын хайрцгийг байршуулна.
2. Хүүхдүүд хүсвэл өөрсдийн нэр, ангиа бичилгүйгээр асуудлаа хуваалцах боломжтой. Эсвэл бусдад (ангийнхаа хүүхдүүдэд, багш нарт, захиралд, сургуулийн ажилтнуудад) хэлж чаддаггүй, асууж зүрхшээдэггүй зүйлсээ бичнэ.
3. Хайрцаг хариуцсан багш, нийгмийн ажилтнууд тогтмол хугацаанд хүүхдүүдийн ирсэн асуулт, саналуудтай танилцаж ерөнхий мэдээлэл, хариултаа самбар дээр гаргана.
4. Шаардлагатай тохиолдолд тухайн сурагчтай уулзаж, хэрэгцээтэй үйлчилгээг өгөхийг хичээгээрэй. (сэтгэл зүйн зөвлөгөө, эмчтэй уулзуулах гэх мэт) Ингэхдээ сурагчийн нууцыг задруулахгүй, чандлан хадгалахаа мартуузай.



ҮЙЛ АЖИЛЛАГАА 2

Ангийн цагийг ашиглан дарамт, дээрэлхэлтээс урьдчилан сэргийлэх арга хэмжээ авах нь

Ангийн цаг зохион байгуулах сэдвүүдийн санаа:

1. Сэтгэл зүйч авчран стресс гадагшлуулах тухай, хосын эрүүл харилцаа, хүчирхийллийн тухай гэх мэт
2. Мэргэжлийн эмч авчран нөхөн үржихүйн эрүүл мэнд, бэлгийн эрүүл мэндийн тухай бүх ангийнханд яриа орох
3. Хүний эрхийн тухай мэргэжлийн хүмүүстэй яриа хийлгэх. Хэрхэн бусдын эрхийг зөрчихгүй байж болох вэ?
4. Өөртэйгөө ажиллах зөвлөгөө
5. Бусдыг идэвхтэй сонсож сурах цаг
6. Ангийн сурагчид хоорондоо нэг асуудлын тухай ярилцах, хэлэлцэх тойрог уулзалт хийх
7. Хамтдаа богино бичлэг, кино үзэж, ном эсвэл богино түүх хүүхдүүд мэдрэмжээ хуваалцаж ярилцах. Жишээ нь янз бүрийн хүмүүсийн амьдралын түүхийг харуулдаг ChoironGoo Facebook-ийн хуудас мөн Өмнөд Солонгосын орчин үеийн уран зохиолын хамгийн алдартай зохиолчдын нэг И Мүн Ёлын “Манай Бүдэрсэн Баатар” тууж
8. Цахим орчны зөв хэрэглээний тухай ярилцах. Хэн нэгний зөвшөөрөлгүйгээр зургийг нь, хувийн мэдээллийг нь, нууцыг нь Facebook, Instagram зэрэгт дэлгэвэл ямар хор уршигтай вэ? Ганц удаа л хүний нууцыг дэлгэхэд амьдралынхаа туршид санаж явах онцгүй дурсамжтай үлдчихнэ гэх мэт олон талаас нь ярилцаж, хүүхэд бүрийн санаа бодлыг бусадтай нь хуваалцуулах.

Ангийн цаг бол сурагчдыг идэвхжүүлэх, хоорондоо илүү ойр байх, бүтээлч байлгах цөөхөн бөгөөд үр дүнтэй боломжуудын нэг байж мэдэх юм. Ангийн цагийг илүү үр дүнтэй, хүүхдүүдэд сонирхолтой бөгөөд өгөөжтэй байлгах үүднээс санал асуулга авч болно. Бэлэн сэдвүүдээс сонгуулах, эсвэл шинэ санаа илэрхийлэх боломж өгч, бяцхан сонгууль ангидаа явуулж болно.

4. ГЭР БҮЛ АСРАН ХАМГААЛАГЧДЫГ ТАТАН ОРОЛЦУУЛАХ НЬ

Үе тэнгийн дарамт дээрэлхэлт нь дан ганц сургууль анхаарал хандуулаад шийдэгддэг асуудал биш юм. Дээрэлхэлтэд өртсөн болон бусдыг дээрэлхэх сөрөг зан үйлтэй сурагчдын гэр бүл, асран хамгаалагчдыг татан оролцуулснаар уг асуудлыг амжилттай шийдвэрлэх боломжтой. Дараах мэдээллийг эцэг эх, асран хамгаалагчдын мэдлэг ойлголт нэмэгдүүлэх, сургуулийн үйл ажиллагаанд оролцуулах зорилгоор оруулж байна.

Үе тэнгийн дарамт, дээрэлхэлтийн асуудлыг байх ёстой болон хүүхдийг сэтгэл зүйн хувьд хатуужуулна гэдэг хандлага байж болохгүй юм. Тиймээс эцэг эх, асран хамгаалагч бүр хүүхдийнхээ сургуулийн амьдралын талаар мэдээлэлтэй байж, санаа тавин, хариуцлагатай хандах үүрэгтэй. Сургууль бол зөвхөн эрдэм мэдлэг олж авах, суралцах орчин биш бөгөөд хүүхдүүдийн амьдралын хамгийн чухал, нийгэмших, өөрийгөө илэрхийлэх, хөгжих, оролцох эрхүүдийн нийлбэр цогц, амьдралд бэлтгэгдэх хөрс билээ. Сэтгэл зүй, үе тэнгийн дээрэлхэлттэй холбоотой ямар нэг асуудал үүсэхэд эцэг эх, сурагчдын хэн нь ч сургуулийн аль ч багшид мэдэгдэж болох бөгөөд ийм нөхцөл бий болгоход идэвхтэй оролцоо чухал юм.

ХЭРВЭЭ ТАНЫ ХҮҮХЭД ДЭЭРЭЛХҮҮЛЖ БАЙВАЛ ДАРААХ ШИНЖ ТЭМДГҮҮД ИЛЭРНЭ. ТА АНХААРЧ БАЙГААРАЙ.

Сургуульдаа явах сонирхол буурах эсвэл хичээлээ таслах	Дарамт, дээрэлхэлт, хүчирхийлэл байгаа орчноос ямар ч хүн зугтдаг.
Сургууль руугаа явдаг замын маршрут нь өөрчлөгдөх	Тухайлбал, хүүхэд тань сургууль руугаа хойд зүгт явдаг байсан бол гэнэт өөр жимээр явж байгаа бол магадгүй өөрийн жим дээр нь хүүхдийг зоддог, гадуур хувцсыг нь булаадаг, хоолны мөнгө нэхдэг хүүхдүүд жим дээр отоод зогсдог болсон байж болзошгүйг анзаараарай.
Сурлагын амжилт буурах	Дээрэлхэлтэнд хэрхэн өртөхгүй байх вэ? гэсэн айдастай үед хичээлдээ төвлөрч чадахгүй, хичээлийн дараа юу тохиолдох бол гэсэн айдас, болгоомжлолтой байх үед, эсвэл өмнөх дээрэлхэлтийн цочролоос гарч амжаагүй байгаа үедээ хичээлдээ бүрэн анхаарч чадахгүй. Дээрэлхэлтэд байнга өртөж байгаа хохирогч нь өөрийн цаг, эрч хүчээ хичээлээ хийе гэхээсээ илүү өшөө авахад илүү төвлөрдөг.
Гэр бүлийн болон сургуулийн үйл ажиллагаанд оролцохоос цааргалах ганцаараа үлдэхийг хүсэх	Та ч мөн ганцаардсан, ичгэвтэр байдалд орсон, айсан, үедээ ганцаараа байх, өрөөндөө өөрийгөө цоожлоод, хэнтэй ч ярихыг хүсэхгүй, орондоо ороод уйлдаг шүү дээ.
Хичээлээ тараад ирэхдээ өлссөн байх	Хоолны мөнгөө хэн нэгэнд булаалгасан эсвэл сургууль дээрээ огт юм идээгүй гэсэн үг.
Байнга мөнгө нэхэх	Халаасны мөнгөө юунд зарцуулсан талаараа тодорхой мэдээлэл өгөхгүй байх, худлаа хэлэх
Гэртээ ирэнгүүтээ жорлон руу гүйх	Дээрэлхэлт хамгийн их үйлдэгддэг цэгийн эхний 4-т сургуулийн жорлон байдаг тиймээс хүүхдүүд шээсээ барих тохиолдол их байдаг. Улмаар шээс бөөрний замын эмгэгт хүрч болзошгүй.
Сөрөг мэдрэмж илэрхийлэх	Утасны дуудлага, зурвас хүлээн авсны дараа, эвсэл социал сүлжээгээр аялсныхаа дараа гунигтай, ууртай, айдастай гэх мэт мэдрэмж илэрхийлэх.
Урьд өмнө нь гаргаж байгаагүй, ааш авир гаргах	Хичээлээ таслах, худлаа хэлэх, хулгай хийх, дүр үзүүлэх
Бусдыг доромжилж, дорд үг хэллэгээр хэлэх	Үе тэнгийнхнийхээ талаар ярихдаа хэт доромжилсон, дорд үзсэн үг хэллэг ашиглаж ярих
Ярилцах дургүй болох	Найз нарынхаа тухай эсвэл сургууль дээр юу болж өнгөрсөн талаар ярихаа болих
Хувцас хунар нь өөр болох	Хувцас нь салбарсан, урагдсан, эсвэл хувцсаа алдсан байх
Гэмтэх, бэртэх нь ихсэх	Бие махбодын гэмтлээ сайн тайлбарлаж хэлж чадахгүй байх
Дэглэм алдагдах	Гэдэс эвгүйрхэх, толгой өвдөх зэрэг зовиурууд байнга хэлэх, шөнө нойрондоо муу болох эсвэл хэт их унтах

Сургуулийн ажилтнууд эцэг эх, асран хамгаалагчтай дээрэлхэлтийн асуудлын талаар ярилцвал тэдний зүгээс ирэх сөрөг хариу үйлдлээс маш болгоомжилдог. Тиймээс нээлттэй, эерэг уур амьсгалтай сургуульд хэн бүхэн энэ асуудлын талаар ил тод, нээлттэй ярилцаж байх чухал. Иймд сургууль дээрэлхэлтийн талаар нээлттэй ил тод ярьж эхэлбэл та “энэ нь хүүхдэд тань эерэг, сайн өөрчлөлт” гэж хүлээн авч хамтран ажиллах хэрэгтэй юм.

Таны хүүхэд дээрэлхэлтэд өртсөн тохиолдолд та юу хийж **БОЛОХ** вэ?

1. Эхлээд хүүхдээ сонс. Хүүхдэдээ итгэ. Хажууд нь үргэлж хамт байна гэдгээ ойлгуулаарай.

Юу болсон бэ? гэж асуугаад хүүхдээ чимээгүй сонс. Хүүхэд болсон явдлын талаар ярьж дууссаны дараа Хэн, Хаана, Хэзээ гэх мэт асуултыг асууж баримтыг цуглуул. Хэрэв шууд эдгээр асуултууд руу үсэрвэл зарим чухал мэдээллийг орхигдуулах магадлалтай.

2. Чиний буруу биш.

Хэн ч дээрэлхүүлэх ёсгүй. Та хүүхдээ “Хэрвээ ингэсэн бол...” Хэрвээ тэгээгүйсэн бол... гэх мэтээр бүү шүү. Таны хүүхэд таны тусламж л хэрэгтэй. Дээрэлхсэн хүүхэд таны хүүхдийг: “хүндлэл хүлээх ямар ч үнэ цэнгүй нэгэн; өөрийгөө хамгаалж чадахгүй; сургууль дээр чамд юу ч тохиолдсон ч ияаж ч чадахгүй; бүгд чамд дургүй” гэх хандлагаар хандаж дээрэлхсэн шүү гэдгийг санаарай.

3. Хариу арга хэмжээ

“Чамд ияаж тусалж болох вэ? Чамд туслахад бэлэн байна, итгэл найдвараа бүү алд, Чи ганцаархнаа асуудлыг шийдэх гэсний хэрэггүй, хамтдаа үр дүнд хүрэх төлөвлөгөө боловсруулья” гэх мэтчилэн хүүхэдтэйгээ ярилцаарай. Дээрэлхэлтийн эсрэг тууштай сөрөн тэмцэх, аюулаас зайлсхийх арга замыг олоход нь та тусалж чадна. Ингэснээр та хүүхдэдээ хүчээ эргүүлэн олж авах, өөрт байгаа авьяас чадвараа хөгжүүлэхэд нь тусалж байна гэсэн үг. Та хүүхэдтэйгээ ямар хариу арга хэмжээ авч болох талаар ярилцаж, сонголтуудад нь анализ хийж, нөхцөл байдлыг бүр дордуулах эсвэл аюултай байдалд оруулах, хүчирхийллийг өдөөх арга хэмжээг нь ялган таниулж хүүхэдтэйгээ ярилцах хэрэгтэй. Улмаар таны хүүхэд бүтээлч байдлаар тууштай дээрэлхэлтийн эсрэг тэмцэх боломжтой.



Таны хүүхэд дээрэлхэлтэд өртсөн тохиолдолд та юу хийж **БОЛОХГҮЙ** вэ?

1. Дээрэлхэлт бол хүн бүрийн туулдаг байдаг л зүйл дээрэлхэгч хүүхдээс хол бай гэж зөвлөж огтхон ч болохгүй.

Дээрэлхэлт бол бие махбод болон сэтгэл зүйн хувьд өвдөлт өгдөг зүйл. Энэ бол зөрчил биш, тоглоом төдий биш, дээрэлхэлт бол эртнээс төлөвлөсөн, зорилготой, онилсон үйлдэл. Дээрэлхэж байгаа хүүхдээс хол бай гэж та өөрийн хүүхдэдээ хэлснээр чи ганцаараа энэ асуудлыг шийд чамд туслах хүн алга гэж хэлж байгаатай ижил.

2. Хүүхдэдээ асуудлыг нь шийдэж өгөх гэж бүү яараарай.

Таны хүүхэд бие махбодийн хувьд хүнд гэмтэл аваагүй бол та нөхцөл байдлыг хяналтандаа оруулах гэж яаран зүтгэснээр дээрэлхэгч хүүхдэд “таны хүүхэд бол дээрэлхэлтийн бай мөн” гэсэн мессеж өгч байгаа гэсэн үг. Мөн үе тэнгийнхэн нь дээрэлхэгч хүүхдийг өмөөрч, таны хүүхэд бол ноомой нэгэн, ээжийн эрх хүүхэд хэмээн буруушаах болно. Харин та хүүхдэдээ өөрийгөө хамгаалах, ухаалгаар дээрэлхэлтийн тохиолдлыг давж гарах аргуудыг заа. Дээрэлхэгч хүүхдэд ч мөн хэрхэн бусдыг дээрэлхэхгүй байхыг томчууд зааж сургах хэрэгтэй.

3. Дээрэлхүү хүүхдээс хол бай гэж хүүхдэдээ бүү хэлээрэй.

Ингэж хэлснээр та хүүхдэдээ зугтаад бай, нуугдаад бай, энэ айдсаа тээгээд яваад бай гэсэн мессэжийг өгч байна гэсэн үг. Дээрэлхэл үйлдэгч хүүхэд айдастай байгаа нэгнийг андахгүй мэднэ. Аюулаас нэн даруй зайлсхийхийн тулд дээрэлхэлээс зугтаж болно. Гэхдээ энэ бол дээрэлхэлийг шийдэх урт хугацааны шийдэл биш.



Таны хүүхэд дээрэлхэлтэд өртсөн тохиолдолд та юу хийж **БОЛОХ** вэ?

4. Дээрэлхэлтийн талаар сургуулийн ажилтнуудад мэдээллээрэй.

Таны хүүхэд дээрэлхэлтэд өртсөн талаар таны хүүхдийн багш мэдэх хэрэгтэй. Та тодорхой баримтуудыг мэдээллээрэй. Тухайлбал сар өдөр, цаг, хаана, хэн гэдэг хэдэн хүүхэд оролцсон, таны хүүхэд хэрхэн хохирсон талаар мэдээлэл өгөөрэй. Мэдээлэл өгсний дараа таны хүүхдийг хамгаалах тал дээр ажиллаж байгаа эсэхийг, өөр хэн нэгний хүүхэд дээрэлхэлтэд өртөж байгаа эсэхийг, дээрэлхэгч хүүхдэд шийтгэл оногдуулахгүйгээр хүмүүжлийн эерэг арга хэмжээ авч байгаа эсэхийг араас нь нягталж хяналт тавиарай.

Харин том хүүхдүүдийн хувьд эцэг эх асран хамгаалагчаа сургууль дээр дээрэлхэлийн асуудлаар очуулах дургүй: Учир нь байдлыг бүүр дордуулна гэсэн итгэл үнэмшилтэй байдаг.



Таны хүүхэд дээрэлхэлтэд өртсөн тохиолдолд та юу хийж **БОЛОХГҮЙ** вэ?

4. Эргүүлээд өөрийг нь дээрэлх гэж хүүхдэдээ бүү хэлээрэй

Яагаад гэвэл дээрэлхэгч хүүхэд хүчний хувьд таны хүүхдээс илүү гэдгээ мэдрээд таны хүүхдийг сонгон дээрэлхэж байгаа. Хэрвээ таны хүүхэд эргүүлж дээрэлхэх гэж байгаад хохирвол дараа түүнийг илүү ихээр хохироох дээрэлхэл хүлээнэ. Өөрийгөө хамгаал гэхдээ өөртөө итгэлтэйгээр ухаалгаар хамгаал. Эргүүлж харилцан дээрэлхдэг хүүхдээс илүү өөрийгөө ухаалгаар итгэлтэйгээр хамгаалдаг хүүхэд илүү амжилттайгаар дээрэлхэлийг сөрж зогсоодог.

5. Дээрэлхэгч хүүхэдтэй мөн эцэг эх, асран хамгаалагчтай ганцаараа уулзаж болохгүй.

Дээрэлхэгч хүүхэд магадгүй эцэг эхээсээ сурсан байж болзошгүй. Магадгүй өөрийгөө өмөөрч, хохирогчийг буруутгана. Гэр бүлийн гишүүд нь мөн хүүхдээ өмөөрнө. Иймд дээрэлхэгч хүүхэдтэй уулзахдаа мөн эцэг эх, асран хамгаалагчтай нь уулзахдаа заавал дэргэдээ дээрэлхэлтийн асуудал хариуцсан сургуулийн ажилтантай хамт сууж уулзаарай.



Хэрвээ таны хүүхэд бусдыг дээрэлхэлдэг бол та юу хийх ёстой вэ?

- ★ Нэн даруй хүүхэд хүмүүжлийн эерэг аргатай эсэхээ нягтлаарай.
- ★ Түүнд "Сайн үйлс хийх" боломж олгоорой.
- ★ Бусдын оронд өөрийгөө тавьж, бусдыг ойлгон энэрэх сэтгэлийг төлөвшүүл.
- ★ Найз нөхөрлөлийн чадвар заа - тууштай, хүндэтгэлтэй, энх тайванч байдлаар бусадтай нөхөрлөхийг үлгэрлэж, заагаарай.
- ★ Хүүхдийнхээ телевиз, социал медиагаар юу үзэж байгааг, ямар видео тоглоом тоглож байгааг, компьютер, гар утсан дээрээ юу хийж, хадгалж авч байгааг, ямар дуу хөгжим сонсож байгааг анхааралтай ажиглаарай. Гэхдээ шууд хувийн утас, социал хаягуудыг хүчээр шалгаж, халдаж огтхон ч болохгүй. Хувийн орон зайг үлдээгээрэй.
- ★ Илүү бүтээлч байдал шаардах, өөрт нь баяр хөөр бэлэглэх, эрч хүч мэдрүүлэх арга хэмжээнд хүүхдээ идэвхтэй оролцуулаарай.
- ★ Дээрэлхүү нэгнээс дээрэлхэлтээс бусдыг авран хамгаалдаг нэгэн болж өөрчлөгдөхөд нь та туслаарай. Бас үүнийг дэмжээрэй.



5. СУРАГЧИД ХАМГИЙН ЧУХАЛ ОРОЛЦОГЧ

Үе тэнгийн дээрэлхэлт, дарамт хүчирхийлэл хүүхдийн эрхийн зөрчил төдийгүй ирээдүйд өөртөө итгэх итгэл, амьдралаа амжилттай удирдан залах, сэтгэлзүйн эмгэгээс өөрийгөө хамгаалахад сөргөөр нөлөөлж байдаг. Тиймээс сурагчид энэ асуудлын талаар насанд хүрэгчидтэй ил тод, нээлттэй ярилцаж тусламж авснаар өөрийгөө хамгаалахаас гадна дахин ийм үйлдлийн хохирогч болох эрсдэлтэй хэн нэгнийг хамгаалж буй хэрэг юм.

Хэрэв намайг дээрэлхэж байгаа бол **БИ ЯАХ ВЭ?**

Хэн ч хэзээ ч үе тэнгийн дээрэлхэлтэд өртөж болзошгүй тул нөхцөл байдлыг сарниулахдаа цөөн хэдэн хувилбартай байх нь дээр. Хэрэв дээрэлхэж байгаа хэн нэгэн танд нөлөөлөхгүй байгааг харвал тэд хүч чадлын мэдрэмжээ алдах болно.

Хэл амаар доромжилсон үгс тан руу хүрч чадахгүй, өөрийгөө “үл үзэгдэх хана” гээд төсөөлөөд үз дээ.

Дээрэлхдэг хүнийг аймшигтай гэж бодохоос илүүтэйгээр тэднийг тэнэг, хөгжилтэй байдлаар бодож, нөхцөл байдлыг айдас багатай болгохыг хичээ.

Хэн нэгэн таныг дээрэлхэхийг оролдох үед өөртөө итгэх итгэлээ алдах нь амархан байдаг. Чамайг үнэлдэг хүмүүст дахин анхаарлаа хандуулаарай.

Хэрэв чи найз нөхдөөр хүрээлүүлсэн нэгэн бол дээрэлхдэг хүүхдүүд халдах магадлал бага байдаг тул ганцаараа үлдэхгүйг хичээ.

Танхай хүүхдүүд өөрсдөөсөө сул дорой гэж боддог хүмүүсийг сонгох хандлагатай байдаг тул чамд хүч чадал, өөртөө итгэх итгэл төрүүлдэг зүйлсийг хий.

Хэрэв чамайг дээрэлхсэн нөхцөл байдлыг ганцаараа шийдэж чадахгүй юм шиг байгаа бол өөр хүнтэй ярилцах эсвэл сургуулийн удирдлага хамт олноос тусламж хүс. Багш эсвэл сургуулийн нийгмийн ажилтан, сэтгэл зүйчид хандаж болно.



Хэрэв хэн нэгэн дээрэлхүүлж байгааг **ХАРВАЛ БИ ЯАХ ЁСТОЙ ВЭ?**

Ангийнхаа найзууд эсвэл бусад танилуудаа дээрэлхүүлж байгааг харсан сурагчид асуудлыг шийдвэрлэхэд туслах олон аргыг ашиглаж болно.

Харж суухаасаа илүү босч холдоод тусламж ав. Та бас бусдыг уриалж болно.

Цуу яриаг нам дараарай. Хэрэв та хэн нэгний тухай үнэн биш эсвэл хор хөнөөлтэй зүйлийг сонсвол мессежийг давтаж, дамжуулж болохгүй.

Өмгөөлөгч бай. Насанд хүрсэн хүнд хэлээрэй. Ялангуяа сургуульд сурч байх үедээ дээрэлхүү хүүхдүүд ихэвчлэн насанд хүрэгчдийн хариу арга хэмжээг мэдээд асуудалд орохоос айдаг. Хэрэв дээрэлхэгч мэдээлэл хэн өгснийг олж мэдэх вий гэж санаа зовж байгаа бол та насанд хүрэгчид мэдэгдэж, энэ яриаг нууцлахыг хүс.

Дээрэлхүүлж байгаа хүнийг насанд хүрсэн хүнтэй ярихыг уриал, дэмж. Ихэнх тохиолдолд дээрэлхүүлж байгаа хүмүүс ямар нэгэн байдлаар тэдний буруу мэт мэдэрдэг. Энэ нь тийм биш гэдгийг тэдэнд мэдэгдээд, сургуулийн нийгмийн ажилтан/сэтгэл зүйчтэй ярилцахыг уриал.

Дэмжлэг үзүүлэх. Дээрэлхүүлсэн нэгэнд анхаарал халамж тавин сайхан сэтгэлээр тусалснаар нөхөрлөл бий болж улмаар урт хугацааны эерэг үр дүнтэй байдаг.

6. ТЭГШ ХАМРУУЛАХ БОЛОВСРОЛЫН САЙН ТУРШЛАГААС СУРАЛЦЪЯ

Сургуулийн орчинд эерэг уур амьсгал бүрдүүлж хүний эрхэд ээлтэй, хүчирхийлэлгүй орчныг бүрдүүлж чадсан сургууль, багш нарын сайн туршлагаас суралъя.

Хэцүү хүүхэдтэй ажиллах нь: Ангид сахилга бат тогтоох аргууд¹

(Жастин Лим, Рөүзменд ахлах сургууль, Өмнөд Калифорни)


Худал хэлэх, хулгай хийх, зодолдох, зугатах, хараал хэлэх, бусдыг санаатайгаар гэмтээх, өшиглөх, уурсаж орилох гээд “зан төлөвийн асуудалтай” хэмээн үзсэн хүүхэдтэй өдөржин зууралдсаар байгаад багш таны тэвчээр алдагдаж байв уу? Жастин Лим багш ийм байдалд орж үзсэн ба багш нарт болон зан төлөвийн өөрчлөлттэй хүүхдэд хичээлийн жилээ үр бүтээлтэй болгоход нь туслах үүднээс зарим зөвлөмжийг хуваалцжээ. Зан төлөв, харилцааны асуудалтай хүүхэд хэзээд байдаг, багш нар тэргүүн шугаманд зогсож өдөржингөө тэдэнтэй нүүр тулдаг. Ийм хүүхдүүд багшийг толгойныхоо үсийг зулгаахад хүргэдэг, уйлуулдаг, ажлаасаа гарах хүртэл тэвчээрийг нь бардаг. ГЭВЧ хүнд бэрх хэдий ч олон жилийн дараа таныг өөрийнхөө ажлыг хүндэтгэн үздэг нэгэн

болгох, багшлах ажилд өөрийгөө зориулсан шалтгааныг тань танд сануулах хүмүүс бол чухам тэдгээр хүүхдүүд юм шүү дээ. Учир нь та энэ хүүхдүүдэд асуудлаа шийдвэрлэхэд нь тусалсан, тэднийг хайрласан нэгэн байсан гэсэн үг. Та ангийнхаа хүүхдүүдийн зан байдлыг зохицуулахдаа хэрэглэдэг аргатай байж магадгүй. Жастин Лин багш ангидаа цаасан тавгаар хийсэн гэрлэн дохио ашигладаг байна. Энэ бол сайн зан чанарыг

бататгаж, дүрэм журам эвддэг зан байдлыг илрүүлдэг арга юм. Хүүхдүүдийн нэрсийг хувцасны хавчаар дээр бичээд ногоон тавганд хавчдаг. Дүрэм зөрчсөнийхээ дараа хүүхдүүд өөрсдийнхөө нэрийг шар гэрлэн дохио руу нүүлгэж хөдөлгөнө, өөрөөр хэлбэл, тэд үүргээ зөрчсөн тул надад 10 минутын завсарлага өгөх үүрэгтэй. Хэрвээ тэд улаан гэрэл рүү нүүвэл надад 20 минутын завсарлага өгөх үүрэгтэй ба гэр рүүгээ санамж бичиг авч явна. Ерөнхийд нь хэлэхэд, ангийн 80 орчим хувьд энэхүү арга сайн үйлчилдэг. Ойролцоогоор хүүхдүүдийн 10 хувь нь сургууль дээрх бүх хугацаандаа сахиусан тэнгэр мэт төгс байдаг. Тэдэнд энэ арга онцын хэрэгцээгүй. Үлдэх 10 хувийн хүүхдэд харин энэ арга төдийлөн цогц биш учраас зан байдлаа бүрэн дүүрэн зөөлрүүлэхэд хангалтгүй, нөгөө талаар тэдний зан байдал нь маш хурц тул тэдэнд илүү хурдан, онцгой үр дүнд хүрэх хөхиүлэн урамшуулах систем хэрэгтэй болдог. Тэр бэрхшээл үүсгэдэг 10 хувийн хүүхдүүдийн талаар ярилцъя.

UIN.MN
СУДАЛГААНЫ САН

¹ “Тэгш хамруулах боловсрол, хүүхэд хамгааллын сайн туршлага” Бүх нийт боловсролын төлөө! Иргэний нийгмийн үндэсний эвсэл, 2020 он



1. Хүүхдийн талаарх нэгдсэн тайланг хянаж үзэх.

Заримдаа өмнөх багшийн үлдээсэн тэмдэглэл, хүүхдийн зан байдлын тодорхойлолт, гаргаж буй зан араншингийн шалтгаан юу болох, бусад санамж зөвлөмж бүхий хувийн нууцлалтай хавтас хэрэглэж болно.

2. Хүүхдийн өмнөх багш нартай ярилцах.

Өмнөх багш нарт нь хүүхдийн гэр бүлийн нөхцөл байдлын талаар зарим санаа бодол, мөн хүүхэдтэй ажиллахад юу нь сайн байсан талаар ашиг тустай зөвлөмж байж магадгүй.

3. Зан үйлийг баримтжуулах

Энэ нь таныг хүүхдийн зан байдлын хэв маягийг илрүүлсэн тодорхой баримттай болгохоос гадна ихэвчлэн ямар төрлийн ааш авир гаргаж буйг харах боломж олгоно.

4. Захиралтайгаа нөхцөл байдлын талаар ярилцах.

Танай ангид юу болоод байгаа, цаашид танд дэмжлэг хэрэг болж магадгүйг захирал, сургалтын менежер, нийгмийн ажилтандаа урьдчилж хэлж мэдэгдээрэй. Манай сургуулийн захирал манай ангид хичээл заах, сурагчийг ангиас хэсэг хугацаагаар гаргахаас эхлээд тус болох зөвлөгөөг сэтгэл харамгүй өгч, урам хайрладаг юм.

5. Эцэг эхтэй нь уулзах.

Хааяа эцэг эхчүүд хүүхдийн зан байдлыг засах таны томоохон холбоотон, хааяа тэд нөгөө “болохгүй” асуудлыг үүсгэж буй эх үүсвэр байдаг. Ихэвчлэн эцэг эхчүүд ТАНД болон хүүхдэдээ туслахыг хүсдэг! Тэдний туслалцаа, оролцоо бол хүүхдээ өөрийгөө хянаж сурахад туслах маш хүчирхэг хэрэгсэл юм. Гол нь харилцаа холбоо!

6. Бататгал, үр дагавар болон хөхиүлэн дэмжих талаар туйлын тууштай байх.

Эдгээр төрлийн хүүхдүүд ихэвчлэн улаан шугам давах, хил зааг зөрчих, багшийг сорихдоо үнэхээр чадварлаг байдаг. Хана шиг бат бэх байгаарай.

7. Сургуулийн захирал, зөвлөх, бусад багш, нийгмийн ажилтан, сэтгэл зүйч зэрэг хүмүүсээс тусламж эрж утасдахад бэлэн байх.

Зарим зүйлс таны ганцаараа учрыг нь олж чадах, зохицуулах чадварын хүрээнээс хэдий нь хальсан байдаг.

8. Зан байдлын гэрээ хийх/одны хүснэгт зохиох

Эцэг эхтэй нь уулзах үедээ би “Зан байдлын гэрээ” байгуулахыг санал болгодог. Өдөр бүр гэр, сургууль хоёрын хооронд явдаг энэ цаас (гэрээ) бол үндсэндээ сурагчийн эерэг, сөрөг зан чанарыг баримтжуулахад ашиглагдах бөгөөд хүүхдүүдэд урам өгч хөхиүлэх эсвэл сөрөг үйлдээ тунгаахыг сануулдаг. Мөн “Харилцах дэвтэр”-ийг санал болгодог. Энэ нь эцэг эхчүүдээс сурагчийнхаа талаарх дараах зүйлийг мэдэж авахад ихээхэн дөхөмтэй байдаг. Үүнд:

- Өглөө хэрхэн яаж эхлэв?,
- Бүтэлгүй эсвэл зарим нэг онцгой зүйлс тохиолдсон уу?

“Харилцах дэвтэр” нь өдрийн турш сурагчдад тохиолдсон эерэг хийгээд сөрөг үйл явдал, тэдгээрийн үр дагавар, цаашдаа тухайн хүүхдийн урам зоригийг хөхиүлэн дэмжихэд туслах мэдээлэл өгдөг. Миний хувьд, сайшаал магтаал болон эерэг, сөрөг зан чанаруудыг нь баримтжуулж бичих зэргээр дэвтрийг ашигладаг. Эцэг эхчүүд өдөр бүр “Харилцах дэвтэр”-тэй танилцан хүүхэдтэйгээ тухайн өдрийнх нь зан зан үйлийн талаар ярилцсаны дараа гарын үсгээ зурдаг. Цахим шуудангаар харилцаж болох ч, тэр нь хэдий хялбар ч гэлээ би хүүхдэд “чи өөрөө сонголт хийдэг, түүнийхээ төлөө хариуцлага хүлээдэг юм шүү!” гэсэн санааг сурагчдад ойлгуулахыг хүсдэг.

9. Урамшуулал болоод үр дагаврын талаар хэлэлцэхдээ хүүхдүүдийг оролцуулж байх.

Эерэг эсвэл сөрөг үр дагаварт хүргэдэг хүн нь хүүхдүүд өөрсдөө байдгийг тэд ойлгож байгаа эсэхийг баталгаажуулаарай. Хүүхдүүдийг урамшуулахдаа өөрсдөд нь чухал, урам өгөхүйц аргыг сонгох хэрэгтэй. Дараа нь тэд өөрийн хийж буй сонголтынхоо төлөө санаа тавьж хичээх магадлалтай. Ихэнх хүүхдүүдийн хувьд гэртээ байх нь том асуудал биш ч гэлээ ТВ, компьютер, видео тоглоомгүйгээр тэд гэрээ төсөөлөхгүй байж мэднэ. Хүүхдэд хамгийн үнэ цэнэтэй зүйл юу болохыг олж мэдээрэй.

10. Эхлээд томоохон сөрөг зан авирыг шийдвэрлэж, жижиг ааш занг үл хэрэгсэх.

Энэ маш хэцүү. Манай ангид нэг сурагч байлаа. Тэрээр бараг өдөр бүр бусад сурагчтай зодолддог тэгээд ч зогсохгүй багшийгаа өшиглөж, цохисон. Би түүний ямар ч бодолгүй чалчих, алиалах, анхаарал татах гэсэн бусад ааш занг нь хайхрахгүй байх ёстой байсан л даа. Эхлээд би түүний гар, хөл, эд зүйлсээ хянаж, хөдөлгөөнгүй байлгаж, өөрийгөө хянасан өдрүүдийг тэмдэглэсэн. Тэгээд тэр үүндээ нэлээн тууштай болж эхлэнгүүт бид тохирсон хариу үйлдэл хийхээр ажилласан юм. Хэдийгээр би түүний тал дээр маш хатуу байр суурьтай байсан ч жилийн эцэст тэр намайг чанга тэвэрсэн юм даа. Тэр намайг “хамгийн сайн багш байсан” гэж хэлээд, миний тэвчээр гаргаж байсанд, мөн түүнд өөрийгөө хянаж сурахад нь тусалсанд талархсан.

БҮХ ЮМ ЧУХАЛ, ШАГНАЛЫН 11

СТРЕССЭЭ ТАЙЛАХ, ДОТРОО ОНГОЙЛГОХ, ТАЙВШРАХ АРГА ЗАМ ОЛОХ.

Багшийн ажил бол нэг талаараа гайхалтай, нөгөө талаараа стресстэй ажил. Хэрвээ танай ангид ааш зангийн өөрчлөлттэй хүүхэд байгаа бол улам л их стресстэнэ. Нэг жил би бусад багш нараас хэрвээ манай ангид намайг 30 минут орловог оронд нь биеийн тамир, зургийн хичээл заах санал хүртэл тавьж байв. Зарим жилүүдэд биеийн тамир, зургийн ангид өөрийгөө хөгжүүлэхийн тулд орж байлаа. Хааяадаа кино үзэж эсвэл номын ертөнцөд татагдан орж өөрийгөө умартан бухимдлаа тайлж байв. Ингэснээр сэтгэлийн зовууриасаа салж дараагийн өдөрт арга барил, хандлагаа өөрчилж, эрч хүчээ сэлбэсэн хүн сургуульдаа ирж чаддаг байлаа. Та юунд тайвширч байгаагаа олж мэдэн, ядарч туйлдсан өдрөө өөрийгөө хайрлах, эмчлэх арга хэмжээ авч байгаарай.

СУРГУУЛИЙН ОРЧИН ДАХЬ ХҮҮХЭД ХАМГААЛАЛ

Дөрвөн шийдэл*

АНУ-ын саяхны статистик үзүүлэлтээр жил бүр 770,000 хүүхэд бие махбод, сэтгэл зүйн болоод үл хайхрах хүчирхийллийн золиос болдог аж¹. Боловсролын салбарын ажилтнууд, сургуулиуд үүний эсрэг санаачилга гаргах чадвартай гэдэгт бүгд санал нийлдэг ч “хүүхдийг хэрхэн хамгаалах вэ?” гэдгээ тодорхойлж, хүүхдийн аюулгүй байдлыг хангахыг ял мэт санадаг. Сургуулиуд шалгалтын оноог л амжилтын үзүүлэлт болгодог тохиолдолд аливаа өөрчлөлт эхлүүлэх хэцүү. Гэтэл сурлагын чанартай эн тэнцүү анхаарал хандуулах ёстой зүйл бол хүүхдийн аюулгүй байдал, хүүхэд хамгааллын асуудал билээ.

Судалгаанд өгүүлснээр үүнийг хийх хамгийн үр дүнтэй арга бол сургуулийн бүх ажилчид, асран хамгаалагчдыг сургах, сурагчдад хүний эрхийн ур чадварын сургалт өгөх явдал аж. Хүүхдийн аюулгүй байдал, хүүхэд хамгааллын тогтолцоо бий болгохын тулд юун түрүүнд “Хүүхэд хамгааллын цогц стратеги” боловсруулан нэвтрүүлэх бөгөөд, стратеги нь дараах бүтэцтэй байх юм. Үүнд:

ЖУРАМ БА АРГАЧЛАЛ;

- Багш, ажилчдад зориулсан сургалт;
- Оюутан, сурагчдад зориулсан сургалт;
- Гэр бүлийн боловсрол.
- Журам ба Аргачлал

Харамсалтай нь хүүхдүүд сургууль дээрээ болон сургалтын бусад орчинд бэлгийн хүчирхийлэлд өртөх нь бий. Сурган хүмүүжүүлэгчдийн зүгээс үзүүлэх бэлгийн дарамтын асуудлыг системтэйгээр авч үзэж судлаагүй болохыг хэд хэдэн судалгааны тоймд өгүүлжээ. Хэдийгээр улсын хэмжээнд багш, сурган хүмүүжүүлэгчдийн бэлгийн зүй бус үйлдлийн талаар нэгдсэн судалгаа байдаггүй ч АНУ-ын Их Сургуулийн Эмэгтэйчүүдийн боловсролын сангийн цуглуулсан тоо баримтаар суралцагчдын 10 хүртэл хувь нь боловсрол эзэмших хугацаандаа багш ажилчдаас бэлгийн дарамтад өртөж байсан гэсэн байна. Түүнчлэн дээрх тоо баримт нь 1991 оноос 2000 оны хооронд ойролцоогоор 290,000 суралцагч төрийн өмчит сургуулийн ажилчдын зүгээс үзүүлсэн биеийн эсвэл бэлгийн хүчирхийлэлд өртсөн болохыг харуулж байна. Сургуулийн орчинд үр дүнтэй журам болон аргачлалыг хэрэгжүүлснээр зүй бус үйлдлээс сэргийлж болох аж.²

Мөн сургуулийн удирдлагын манлайлал нь сургуульд суурилсан урьдчилан сэргийлэх хөтөлбөрийн тогтвортой байдал, хүрэх амжилтанд чухал нөлөөтэй байдаг аж. Сургуулийн удирдлага “хүүхэд хамгаалал бол нэн тэргүүний чиглэл” гэсэн мессэжийг түгээж, багш, ажилчдыг сургалтаар олж авсан чадвараа амьдралд хэрэгжүүлэхэд сэдэлжүүлэх, дэмжих боломжтой.

Сургуулийн удирдлагууд өөрийн сургуульдаа тохирсон хүүхэд хамгааллын стратегийг боловсронгуй болгохын тулд одоо хэрэгжиж байгаа хүүхэд хамгааллын дүрэм журам, аргачлал, туршлагандаа үнэлгээ, дүгнэлт хийх зайлшгүй шаардлагатай.

* 2014 Committee for Children, SecondStep.org

- 1 Монгол Улсын тухайд Хүний эрхийн Үндэсний Комиссын “Хүний эрх, эрх чөлөөний нөхцөл байдлын талаарх 16 дахь илтгэл” -д дурдсанаар 10 хүүхэд тутмын 8 нь ямар нэгэн хүчирхийлэлд өртсөн ба давтамжийн хувьд бие махбодийн хүчирхийлэлд хамгийн их өртдөг ба энэ нь гэр бүл, сургуулийн орчинд хамгийн их гардаг байна. Асуулгад хамрагдсан 2 хүүхэд тутмын 1 нь амьдарч буй орчноо аюулгүй, хамгаалагдсан гэж үздэггүй бөгөөд 38.3 хувь нь сургуулийн орчноос (багш, сургуулийн атаман, нийгмийн ажилтан, дотуур байрны багшаас) хамгийн их айдаг хэмээжээ.
- 2 Монголд энэ судалгааг Хүний эрхийн Үндэсний Комиссын дэмжлэгтэйгээр “Өөрчлөлтийн төлөө эмэгтэйчүүд” ТББ хийсэн бөгөөд зөвхөн их, дээд сургуулийн орчинг онцлон үзсэн байдаг.

Сургуулийн удирлагуудад сургуулийнхаа хүүхэд хамгааллын одоо хэрэгжиж буй журам, аргачлал, туршилгаа үнэлж дүгнэхэд нь туслах чанартай сургалт нэн шаардлагатай. Чанартай сургалт нь сүүлийн үеийн судалгаа, сайн туршлагыг дэмжсэн хүүхэд хамгааллын цогц стратегийг боловсруулахад дэмжлэг болох юм. Судалгаа, сайн туршилтад тулгуурласан стратеги гэдэгт нь сургуулийн болон хүүхэд залуучуудын хөтөлбөрийн орчинд хүүхдийг хүчирхийллээс хамгаалах, багш ажилчдын ёс зүйн дүрмийг тогтоох, сайн дурын ажилчид болон шинэ ажилчдыг сонгон шалгаруулах журам гаргах, хүүхэд хамгааллын журам зөрчсөн ажилчдыг мэдээллэх, хариуцлага хүлээлгэх зэрэг багтана.

Багш ажилчдад зориулсан сургалт

Багш нар сургуулийн ямар ч ажилтнаас илүү сурагчидтай ойр байдаг учраас тэд шууд оролцоогоор дамжуулан сурагчдынхаа эрүүл мэнд, аюулгүй байдлыг хамгаалах боломж ихтэй. Багш, сургуулийн удирдлага хүүхдийн эсрэг хүчирхийллийг тайлагнаж мэдээлэх маш том үүрэг хариуцлага хүлээдэг. Хэдий тийм боловч багш, сургуулийн удирдлага энэхүү үүрэг хариуцлагаа бүрэн дүүрэн үүрэхэд нь саад болдог хэд хэдэн бэрхшээл байдаг болох нь судалгаагаар илэрчээ. Үүнд,

- Багш нар хүчирхийллийн шинж тэмдгийг ялган таних мэдлэггүй байна. Багш нар хүчирхийллийн тохиолдлыг дутуу мэдээлж байгаа нь:
 - хүчирхийллийн шинж тэмдгийн талаар хангалттай мэдэхгүй, эсвэл
 - хүчирхийллийн мэдээллийг хаана хэнд мэдүүлэх нь тодорхой бус,
 - буруу мэдээлэл өгчих вий гэсэн айдсаас үүдэлтэй болох нь судалгаагаар тогтоогджээ.

Багш нар жендэрт суурилсан хүчирхийллийн талаарх сургалтад маш бага сууж буй тул хүчирхийллийн шинж тэмдгийг таних, мэдээлэх арга зүйн сургалтыг илүү олон зохион байгуулвал багш нарт ашиг тусаа өгөх нь гарцаагүй юм. Багш, ажилчдын боловсрол бол үр дүнтэй хүүхэд хамгааллын хөтөлбөрийг хэрэгжүүлэх гол хүчин зүйлсийн нэг билээ. Хүчирхийлэл болон үл хайхралтын суурь шинж тэмдгийг ялгаж таних сургалт нь болзошгүй хүчирхийллийг олж таних болон хүүхэд хүчирхийлэлд өртсөн эсвэл, үл хайхрагдаж байгаа гэсэн үндэслэлтэй үед сургуулийнхаа журмын дагуу мэдүүлж сургахад багш нарыг бэлтгэх юм.

Оюутан, сурагчдад зориулсан сургалт

Хүүхдийг бэлгийн хүчирхийллээс сэргийлэхэд ашиглагддаг хамгийн түгээмэл арга бол сургалтын хөтөлбөрт нь энэ сэдвийг оруулах явдал юм. Хүүхдүүд хүчирхийллээс сэргийлэх, хувийн аюулгүй байдлаа хамгаалах олон ур чадварт ялангуяа, бэлгийн хүчирхийлээс сэргийлэх чадварт суралцах чадамжтай гэдгийг олон судалгаа харуулсан байдаг. Тухайлбал, урьдчилан сэргийлэх сургалтад хамрагдсан оролцогчдын хувийн аюулгүй байдлаа хамгаалах мэдлэг чадварын статистик үзүүлэлт нь хяналтын бүлгийн хүүхдүүдээс өндөр байжээ. Урьдчилан сэргийлэх хөтөлбөрийн сургалтыг (загварчлах, сургуулилах, бататгах) идэвхтэй арга барилаар заавал уламжлалт сургалтаас ч илүү мэдлэг, чадвар олгож олгодог.

Гэр бүлийн боловсрол

Хүчирхийллээс урьдчилан сэргийлэх, хамгаалах хүчин чармайлт, үйл ажиллагаанд гэр бүл, асран хамгаалагчдыг татан оролцуулах нь чухал. Гэр бүл нь хүүхэд хамгаалалд гол үүрэг гүйцэтгэдэг бөгөөд тэд хэн нэгэн хүүхэдтэй зүй бус харьцахаас хамгийн сайн хамгаалах чадвартай. Судалгааны үр дүнгээр сургуулиуд эцэг эх, асран хамгаалагч нарт хүүхдийн хүчирхийлэл, үл хайхралтын талаар боловсрол олговол тэд хүүхдийг урьдчилан сэргийлэх, хамгаалахад хүлээх үүрэг хариуцлагаа бүрэн ухамсарлахад нь тусалж чадна гэжээ.

АЮУЛГҮЙ БАЙДЛАА ХАДГАЛАХ НЬ

Хойд Ирландын урьдчилан сэргийлэх боловсрол¹

Маш олон хүүхдүүд хүчирхийллийн шинж чанартай зан үйл болоод өөрт нь заналхийлж буй хүнийг ялган таних чадваргүй байдаг ба хэнээс, хаанаас, яаж тусламж авахаа мэддэггүй. Урьдчилан сэргийлэх боловсрол олгох нь хүүхдүүдэд өөрсдийгөө хамгаалахад хэрэгтэй мэдлэг, үр чадварыг олгодог бөгөөд энэ нь хүчирхийллийг эрт олж илрүүлэхэд тустай.

Сургуулийн ажилтнууд, эцэг эхчүүдийн хувьд хүүхдүүдтэйгээ бэлгийн хүчирхийлэл, гэр бүлийн хүчирхийлэл зэрэг эмзэг сэдвийн талаар ярилцахад хэцүү байдаг гэдгийг бид мэднэ. Энэхүү хөтөлбөр нь эцэг эхчүүд болон сургуулиудад эдгээр сэдвүүдээр хүүхдүүдтэйгээ ярилцах болон хүүхдүүдийг хүчирхийллээс ангид, аюулгүй байлгахад тусална.

ГОЛ ОЛОЛТ:

Гэр бүлийн, бэлгийн хүчирхийлэл зэрэг асуудлын талаарх хүүхдүүдийн ойлголт болон мэдлэгт асар том ялгаа байдаг. Хүүхдүүд хүчирхийлэлд өртсөнөө өөрийн итгэлтэй насанд хүрэгчид хэлэх эсэхтээ ч эргэлздэг. Багш нар ийм сэдвээр хичээл заахыг ихэвчлэн зөвшөөрдөг ч гэлээ энэ чиглэлийн сургалт, тогтвортой туслалцаа тэдэнд хэрэгтэй.

Эцэг эхчүүд хүүхдүүддээ аюулгүй байдлаа хамгаалах талаар хичээл оруулах сонирхолтой байсан ч тэдэнтэйгээ энэхүү эмзэг асуудлын талаар хэрхэн ярилцахаа мэддэггүй. Бүх хууль зүйн болон сайн дурын салбарын байгууллагууд харин өөр хоорондоо нягт хамтран ажиллаж, үр дүнтэй урьдчилан сэргийлэх боловсролыг хөгжүүлэх хэрэгтэйг хүлээн зөвшөөрдөг.

БАГА СУРГУУЛИЙН ЖЕНДЭРТ СУУРИЛСАН ХҮЧИРХИЙЛЛИЙН ЭСРЭГ АВЧ ХЭРЭГЖҮҮЛЖ БУЙ АРГЫН НЭГ БОЛОХ ХҮҮХЭД ХАМГААЛЛЫН ПРАКТИКИЙГ АУДИТ ДАРААХ БАЙДЛААР ҮНЭЛЖЭЭ.

1. Сургуулиуд сурагчдад аюулгүй байдлаа хамгаалах талаарх мэдлэг олгож байсан ч илүү эмзэг сэдвүүдэд мэдлэгийн хоосон орон зай байсаар байгаа;
2. Танихгүй хүний зүгээс хүүхдэд учруулж болох эрсдлийн талаар хангалттай ач холбогдол өгч ярьдаггүй. Заах арга барил нь хүүхдүүдийн гол чадваруудыг дээд түвшинд хүртэл сайжруулах боломж олгоогүй;
3. Аюулгүй байдлаа хамгаалах сургалт бага насны болон тусгай сургуульд суралцаж буй хүүхдүүдэд бараг ордоггүй.

ХЭРХЭН САЙЖРУУЛАХ ВЭ?

- Багш, ажилчид хүүхдүүдэд дээрэлхэлт болон бусад бүх төрлийн хүчирхийлэл, үл хайхруулах зэргээс өөрийгөө хэрхэн хамгаалахыг зааж сургах;
- Улирал болгоны эхэнд сургуулийн ахлагчид чуулга уулзалтад оролцож тухайн улирлын сэдвийг танилцуулна. Чуулга уулзалтын дараа багш тус бүр сурагчдын насны ангилалд тохирсон гурван хичээл заана. Хичээлдээ цахим ном, анимейшны баатрууд, түүх, хэмнэлт шүлгүүд, цагаан самбар ашиглан харилцах замаар хүүхдийг сурах үйл ажиллагаанд оролцуулна;
- Гэртээ суралцах нөхцөл бий болгохын тулд хичээл бүрийн гэрийн даалгавар нь эцэг эхчүүдийг оролцуулахад чиглэсэн байх бөгөөд гарын авлага, материал нь эцэг эхчүүдэд эмзэг сэдвээр хүүхэдтэйгээ ярихад туслахуйц тусгайлан хийгдсэн байна.

¹ Хойд Ирландын урьдчилан сэргийлэх боловсрол, <https://learning.nspcc.org.uk/services/keeping-safe-preventative-education-in-northern-ireland>

СУРГУУЛИЙН АЖИЛЧДАД ЗОРИУЛСАН СУРГАЛТ, ДЭМЖЛЭГ

Энэхүү хөтөлбөр нь сургуулийн нийт хамт олны хүчин чадлыг бүрэн бэхжүүлж, сургуулийн нийт хамт олонд хамгийн эмзэг, аюулгүй байдлаа хадгалах сэдвээр заах аргын чадварыг сайжруулж, мөн хөтөлбөрийг сургуулийн амьдралын бүхий л хүрээнд нэвтрүүлнэ.

- Сургалтыг танхимаар болон цахимаар хүргэнэ;
- Хөтөлбөрийг танилцуулна, ажилтан, албан хаагч нэг бүр маш чухал үүрэг хариуцлага үүрч байгаа гэдгээ ухамсарлан бататгана;
- Урьдчилан сэргийлэх боловсролыг хэрхэн сургуулийн амьдралын бүх хүрээнд тусгаж олгох вэ? гэдгийг авч үзнэ;
- Урьдчилан сэргийлэх боловсролыг мэдээлж дамжуулах ажилтнуудад тусална
- Ажилтнууд өөрсдийгөө бэлдэхэд тусална. Хөтөлбөрийг дамжуулахын өмнө хүүхдүүд, анги танхимыг бэлдэхэд нь тусална.

Багш, ажилчид албан бус сургалтын хөтөлбөрөөр буюу зурагт хуудас, эргэн сануулах үзүүлэн, ярианд оролцуулах, ажиглалт хийх, журам боловсруулахад хүүхдүүдийг оролцуулах тогтолцоог урамшуулах, эерэг зан үйлийг үлгэр жишээ болгох замаар аюулгүй байдлаа хамгаалах мэдээллийг түгээнэ.

7. НЭМЭЛТ: АНХААРАХ НЭГЭН ЗҮЙЛ

Хүн бүрд хувийн орон зай бий. Сургуулийн орчинд бүх хүмүүс аюулгүй мэдрэмж авч, тайван байхыг үргэлж бие биендээ анхааруулан, хоорондоо ярилцаж байгаарай. Сургуулийн ханан дээр энэ зургийг зурж, хүний хувийн орон зайг яагаад хүндлэх ёстой талаараа ярилцах цаг гаргаж болно. Багш нар хүүхдийн биед халдаж болохгүй талаар, сурагчид хоорондоо бие биенээ хүндэтгэх тухай гэх мэт.

ХУВИЙН ОРОН ЗАЙ

Та хэн нэгний хувийн орон зайруу халдаж байгаагаа мэдэхгүй байгаа юм биш биз!

Миний хувийн орон зай



Хэн нэгний биеийн гадаад үзэмжээр далимдуулан шоглох, хоч өгөх, доромжлох

Хүсэхгүй, дургүй байхад нь биед нь хүрэх, тэврэх, үнсэх, гижигдэх, барилдах, ноцолдож тоглох, биеийн эмзэг хэсгүүдэд хүрэх

Хүүхэд ариун цэврийн өрөө ашиглаж байхад дураараа хаалга онгойлгох, хаалгыг нь нүдэх

Бусдын нийгэм, сэтгэл санаа болон бие махбодийн хил хязгаарыг үгүйсгэн тэднийг тааламжгүй эвгүй байдалд оруулах

Тохуурхсан, үл ойшоосон үг хэллэг хэрэглэн өөрийн хил хязгаар, хувийн орон зайг нь үгүй хийх

ДЭЭРХ БҮГД ХУВИЙН ОРОН ЗАЙД ХАЛДАЖ БУЙ ХЭЛБЭРҮҮД.



Хувийн орон зайд юу хамаарах вэ?

Биеийн бүхий л хэсэг (ил болон далд бүх эрхтэн)

Яагаад хувийн орон зайд халдаж болохгүй вэ?

- Энэ бол хүний эрхийн зөрчил юм. Хүний хувийн орон зайд халдах нь дарамт, хүчирхийллийн нэг хэлбэр болно.
- Үр дагавар нь үргэлж сөрөг байдаг. Хувийн орон зайд халдсанаар сэтгэл зүйн хувьд ичих, өөртөө итгэлгүй болох, сэтгэл гутралд орох, айх, сандрах, цочих, нойргүйдэх, хар дарж зүүдлэх, түгших зэрэг сөрөг үр дагаврууд бий болдог.
- Мөн бусдын хувийн орон зайд халдах түүнийг хэвийн гэж үзэх нь дээрэлхэлт, дарамт, хүчирхийллийн талаар ойлголтогүй болох, яваандаа хүчирхийллийг хүлцэн тэвчих хандлагатай болох аюултай.

Дээрх бүгд хувийн орон зайд халдаж буй үйлдэл
БУСДЫН ХУВИЙН ОРОН ЗАЙГ ХҮНДЭТГЭЕ.

ДЭЭРЭЛХЭЛТИЙН ЗАН ҮЙЛИЙГ БҮРТГЭХ, ТЭМДЭГЛЭХ ХУУДАС

1. Дээрэлхүүлсэн сурагчийн нэр, анги

Нэр _____

Анги _____

2. Дээрэлхэлтэд оролцсон сурагч(д)ийн нэр(с), анги(уд)

3. Дээрэлхэлтийг мэдээлсэн эх сурвалж (дөрвөлжинг(үүдийг) тэмдэглэ)*		4. Дээрэлхэлт болсон газар (дөрвөлжинг(үүдийг) тэмдэглэ)*	
Дээрэлхэлтэд өртсөн сурагч		Тоглоомын талбай	
Өөр сурагч		Анги	
Эцэг, эх/асран хамгаалагч		Корридор	
Багш/ажилтан		Ариун цэврийн өрөө	
Бусад		Цайны газар	
		Бусад	

5. Дээрэлхэлтийг мэдээлсэн хүний нэр(с)

6. Дээрэлхүү зан үйлийн хэлбэр (дөрвөлжинг(үүдийг) тэмдэглэ)*

Бие махбодын түрэмгийлэл		Цахим дээрэлхэлт	
Эд зүйлсийг эвдэн сүйтгэх, хулгайлах		Айлган сүрдүүлэх	
Гадуурхах/тусгаарлах		Муулж, хов, цуу яриа тараах	
Нэр хоч өгөх		Бусад (бичнэ үү)	

7. Дээрэлхэлтийн зан үйл хувь хүний амин чанарт суурилсан бол холбогдох ангиллыг тэмдэглэнэ үү:

Хүйс, жендэр	Хөгжлийн бэрхшээл	Үндэс угсаа, гарал үүсэл	Эмзэг, ядуу байх	Бусад (бичнэ үү)

8. Дээрэлхүү зан үйл, түүний үр нөлөөг товч дүрсэлж бичнэ үү

9. Авсан арга хэмжээг тодорхой бичнэ үү

Гарын үсэг _____ (Хариуцсан багш)

Огноо _____

Сургуулийн захирал \ нийгмийн ажилтанд хүлээлгэн өгсөн өдөр _____

ДЭЭРЭЛХЭЛТИЙН ЭСРЭГ ЖУРМЫН ХЭРЭГЖИЛТ БОЛОН БИЕЛЭЛТИЙГ ШАЛГАХ АСУУЛГА

Сургуулийн зөвлөл нь сургуулийн дээрэлхэлтийн эсрэг журам болон түүний хэрэгжилтэд жил бүр хяналт хийнэ. Энэхүү зорилгоор доорх хяналтын асуултууд ашиглагдана. Энэхүү хяналтын асуултууд дотоод мониторингийн зорилгоор ашиглагдах бөгөөд шалгах зорилготой биш. Энэхүү хяналтын асуулгыг бөглөхийн тулд сургуулийн дээрэлхэлтийн эсрэг журмыг хэрэгжүүлэх төрөл бүрийн элементүүдийг, тоон ба чанарын анализуудын хамтаар хянан үзэх хэрэгтэй болохыг анхаарна уу.

Сургуулийн зөвлөл бага, дунд, ахлах ангид “Дээрэлхэлтийн эсрэг авах үйл ажиллагааны дэс дараалалтай, дэс дараалалын дагуу авах арга хэмжээний жагсаалттай журмыг баталсан эсэх	
Сургуулийн зөвлөлөөр батлагдсан журмыг сургуулийн цахим хуудас дээр байршуулсан, мөн эцэг эхийн зөвлөл/сургуулийн эцэг эх, асран хамгаалагч, багшийн холбоонд хуулбарлан өгсөн эсэх	
Сургуулийн зөвлөлөөр батлагдсан журам нь сургуулийн нийт багш, ажилтнуудад (шинэ ажилтанд) хүртээмжтэй байгаа эсэхийг нягтлан шалгасан эсэх	
Сургуулийн ажилтнууд журмыг хангалттай сайн мэдэж байгаа эсэх, журмын дагуу үйл ажиллагааны дэс дарааллыг ягштал баримтлан ажиллаж байгаа эсэх, энэхүү дэс дараалал тэдний өдөр тутмын ажлын нэг хэсэг болсон эсэхэд Сургуулийн зөвлөл сэтгэл хангалуун байгаа эсэх?	
Журмын талаар бүх сурагчид хангалттай мэдээлэлтэй байгаа эсэхийг Сургуулийн зөвлөл нягталсан эсэх?	
Сургууль үе тэнгийн дээрэлхэлтлээс урьдчилан сэргийлэх стратегиа журамдаа баримтжуулан оруулсан эсэх?	
Журамд орсон урьдчилан сэргийлэх болон стратегиудыг хэрэгжүүлсэн эсэх?	
Хэрэгжүүлсэн урьдчилан сэргийлэх болон стратегиудын үр ашигтай байдлыг шалгасан эсэх?	
Бүх багш нар журмын дагуу дээрэлхэлтийн тохиолдол бүрийг бүртгэж, шийдвэрлэж байгаа эсэхэд Сургуулийн зөвлөл сэтгэл хангалуун байгаа эсэх?	
Сургуулийн зөвлөл захирлын цаг үеийн хураангуй тайланг хүлээн авсан эсэх? Сургууль дээрэлхэлтийн мэдүүлгүүдийг түүнчлэн дээрэлхэлтийг эрт үе дээр нь анхааран сайн шийдвэрлэсний улмаас захирлаас Сургуулийн зөвлөлд очиж байгаа цаг үеийн тайланд дурдагдаагүй байгааг зөвлөл хэлэлцсэн эсэх?	
Сургуулийн зөвлөлд дээрэлхэлтийн асуудал дээр сургууль хэрхэн хандаж ажиллаж байгаа талаар эцэг эх, асран хамгаалагчдаас гомдол ирсэн эсэх?	
Дээрэлхэлтийн асуудлыг сургууль шийдвэрлэж байгаа нь таалагдаагүйн улмаас хүүхдээ тухайн сургуулиас гаргасан эцэг эх, асран хамгаалагч бий эсэх?	
Дээрэлхэлтийн тохиолдолд хүүхэд хамгааллын бодлогын дагуу хянан шинжилсэн эсэх?	
Захиралд тайлагнаж буй тохиолдлуудын датад (дээрэлхэлтийг бүртгэх маягтын дагуу бөглөгдсөн) анализ хийж асуудлуудыг илрүүлэн гаргасан эсэх, дээрэлхэлтийн зан үйлийн хандлагууд болон төлөв байдалд шинжилгээ хийсэн эсэх?	
Аль нэг хэсгийг сайжруулан шийдэх талаар Сургуулийн зөвлөл үйл ажиллагааны төлөвлөгөө гаргасан эсэх?	

Зөвлөлийн дарга

Гарын үсэг: _____ Захирал _____

Огноо _____

УДИРДАХ ЗӨВЛӨЛИЙН ДЭЭРЭЛХЭЛИЙН ЭСРЭГ ЖУРАМД ХИЙСЭН ХЯНАЛТЫН ЖИЛИЙН ТОЙМ

Хэнд: _____

Удирдах Зөвлөлийн _____ мэдэгдэх нь:

Удирдах Зөвлөлийн дээрэлхэлтийн эсрэг журам болон хэрэгжилтийн жилийн тоймыг зөвлөлийн _____ (огноо) хуралдаанаар авч хэлэлцэв.

Энэхүү тойм нь ЕБС-ийн сургуулийн дээрэлхэлтийн эсрэг үйл ажиллагааны дэс дарааллын хавсралт 2-т тусгагдсан хяналтын жагсаалтын дагуу гүйцэтгэгдсэн болно.

Гарын үсэг _____

Удирдах зөвлөлийн дарга _____

Огноо _____

Гарын үсэг _____

Захирал _____

Огноо _____







UIH.MN
СУДАЛГААНЫ САН

ДЭЭРЭЛХЭЛТ ДАРАМТАД ӨРТСӨН ЭСВЭЛ ҮЕ ТЭНГИЙН ДЭЭРЭЛХЭЛТ, ДАРАМТЫН ТАЛААР СУРГАЛТ МЭДЭЭЛЭЛ АВАХААР ХАНДАЖ БОЛОХ ГАЗРУУДЫН МЭДЭЭЛЭЛ

№	Байгууллагын нэр	Холбоо барих мэдээлэл
1	Гэр бүл, хүүхэд, залуучуудын хөгжлийн газар (Нийслэл болон дүүргийн салбар хэлтэсүүд)	6226-2109
		
2	Хүүхдийн тусламжийн утас	108
		
3	Цагдаагийн шуурхай дуудлага, мэдээлэл хүлээн авах утас	102
		
4	Хүчирхийллийн эсрэг үндэсний төв, зөвлөгөө өгөх утас	7011 9949 9649 0505
		
5	“Хөөрхөн зүрх” ТББ	7015 9688
		
6	Боловсролын зөвлөгөө мэдээллийн төв	11- 31 9016
		
7	Боловсролын Хамтын Ажиллагааны Нийгэмлэг	11- 310663 9987 5949
		

ТАЙВШРАХ АРГУУД:

Та бүхнийг хэн нэгэн эсвэл ямарваа нэг тохиолдол тавгүйтүүлж, хувийн орон зайд тань халдаж, сэтгэл санааг тань цочроосон бол дараах аргуудаас хэрэглээд үзээрэй.

Зураг/icon	Тайвшрах аргын төрлүүд	Санал болгох арга
	Сонсож тайвшрах	-Дуртай дуугаа сонсох -Хэн нэгэнтэй ярилцах -Байгалийн чимээ сонсох
	Хөдөлгөөн хийж тайвшрах	-Дасгал хийх -Гэрээ/ангиа цэвэрлэх -Алхах
	Идэж тайвшрах	-Дуртай амттанаа хэмжээг нь тохируулан идэх -Амттай цай уух
	Харж тайвшрах	-Дуртай киногоо үзэх -Ном унших -Зураг, альбом үзэх -Байгаль харах, ажиглах
	Үнэрлэж тайвшрах	-Мод, навч, цэцэг үнэрлэх -Сэнгэнэсэн үнэр ууршуулах -Үнэрт тос ууршуулах
	Хүрэлцэж тайвшрах	-Хайртай, дотны хэн нэгнээ тэврэх

НЭР ТОМЬЁОНЫ ТАЙЛБАР

Боловсролын салбар дахь хүүхэд хамгаалал Сургалтын байгууллага хүүхэд хамгааллын бодлогыг хэрэгжүүлэхдээ хөтөлбөр, төлөвлөгөө гаргах, хүүхэд бүрийг тухайн орчинд бие махбодийн шийтгэл, сэтгэл зүйн болон үе тэнгийнхний дарамт, үл хайхрах байдал, гэмт хэрэг, зөрчил, хорт зуршилд өртөхгүй байх нөхцөлийг бүрдүүлэхийн тулд хэрэгжүүлэх арга хэмжээнүүдийн цогц.

Эрсдэлт нөхцөлд байгаа хүүхэд Эрүүл мэнд, амь нас, аюулгүй байдал, хөгжих хэвийн орчин нь алслагдсан, эсхүл асран хамгаалагч, харгалзан дэмжигч, хууль ёсны төлөөлөгчгүй, эсхүл гамшиг, онцгой байдлын нөхцөлд байгаа хүүхдийг хэлнэ. (Хүүхэд хамгааллын тухай хууль, 2016)

Жендэрт суурилсан хүчирхийлэл гэж жендэрээс үүдэлтэйгээр бусдад бие махбодийн, бэлгийн, сэтгэл санааны гэм хор, эдийн хохирол учруулсан, учруулж болзошгүй үйлдэл, эс үйлдэхүйг хэлнэ. (Жендэрийн тэгш байдлыг хангах тухай. МУ-ын хууль. 4.1.8)

Тэгш хамруулах боловсрол (inclusive education) нь бүх суралцагчдын нийгэм, соёл, боловсролын үйл ажиллагаан дахь тэгш оролцоог хангах, боловсролын гаднах болон доторх бүх хэлбэрийн ялгаварлан гадуурхалтыг бууруулах замаар сурагч бүрийн ялгаатай хэрэгцээнд нийцүүлэн боловсролын үйлчилгээг хүргэх үйл явц мөн. Суралцагсдын харилцан адилгүй байдал, ялгаатай хэрэгцээ, хэл соёл, нийгмийн гарал, эдийн засгийн хүчин зүйлсээс үл хамааран хүн бүрийн мэдлэг чадвараа дээшлүүлэх, боловсрол эзэмших тэгш боломж болон эрхийг хангахад чиглэсэн үйл явц юм. (Юнеско-ийн Монголын Үндэсний комисс, 2014).

Тэгш хамруулан сургах боловсрол нь суралцагч бүрийг эрх эдлэгч гэж үздэг, тэднийг сургуулийн нэгэн булангаас анхаарлын төвд авчирдаг. Энэ нь хувь хүний бэрхшээлээс илүү нийгмийн нөхцөл байдалд анхаарлыг шилжүүлж байгаа хэрэг юм. Тэгш хамруулан сургах тогтолцоо нь хүүхэд боловсролын тогтолцоонд зохицохоос илүү боловсролын тогтолцоо хүүхдэд зохицохыг баталгаажуулахын тулд боловсрол, орон нутгийн, бүлгийн өөрчлөлтийг дэмждэг. Тэгш хамруулан сургах тогтолцоо нь хувь сурагчдын ялгаатай хэрэгцээнд тохируулах, тэр боломжид саад болж байгаа саад тотгорыг арилгахын тулд сургууль дахь соёл, бодлого, практик үйл ажиллагааг өөрчлөн зохион байгуулах шаардлагыг хүлээн зөвшөөрдөг.

Хүний эрх: Хувь хүн болон нийгмийн бүлгийн байгалиас заяамал эрхийг зөрчигдөж, алдагдахаас хамгаалах суурь эрхийн баталгааны цогц юм. Эдгээр эрх хүн бүрт тэгш заяагдсан ба өөр хэн нэгэн дэлхийн аль ч хэсэгт, ямар ч тохиолдолд, ямар ч шалтгаанаар энэ эрхийг нь зөрчих ёсгүй. Хүний эрхийг салшгүй, хуваагдашгүй, харилцан хамааралтай гэж тодорхойлдог. (Монголын Эмнести интернэшнл “Хүүхдэд ээлтэй сургууль болох нь” гарын авлага)

Хүний эрхэд суурилсан хандлага: хүний эрхэд суурилсан хандлага гэдэг нь олон улсын хүний эрхийн жишиг хэмжээнд тулгаарлан хүний эрхийг хамгаалах, хөхиүлэн дэмжих замаар хүнийг хөгжүүлэх үйл явцын цогц суурь юм. Энэ нь хөгжлийн асуудлаас хамааран үүссэн тэгш бус байдлыг халах, алагчлах байдлыг жигшиж, хөгжлийн үйл явцад саад болох шударга бус эрх мэдлийг зогсооход оршино. (Ази Номхон далайн форум, 2015 он, “Хүний эрхийн боловсрол”)

Үе тэнгийн дарамт дээрэлхэлт: Үе тэнгийнхний дарамт бол сэтгэл санааны болоод бие махбодийн хүчирхийллийн нэг хэлбэр бөгөөд санаатай, давтамжтай, хүчний тэнцвэргүй гэсэн гурван шинжтэй байна (Боловсролын зөвлөгөө мэдээллийн төв, гарын авлага)

Бэлгийн чиг баримжаа Бэлгийн чиг баримжаа гэдэг нь, хүн бүрийн хэн нэгэнд сэтгэл, бие махбодь, хайр дурлалын хувьд татагдах төрөлхийн өөрчлөгдөшгүй мөн чанар, мэдрэмж юм. Бэлгийн чиг баримжааг ерөнхийд нь 3 ангилдаг. Үүнд: 1) Эсрэг хүйсийнхээ хүнд татагддаг бол стрэйт 2) Ижил хүйсийнхээ хүнд татагддаг бол гей, лесбиян, 3) Аль аль хүйсийн хүнд татагддаг бол бисексуал гэдэг.

Маргиналчлагдсан бүлэг Нийгмийн тэгш бус байдлаас үүдэлтэйгээр урт хугацаанд гадуурхагдаж, боловсролын бодлого төлөвлөлтийн шийдлээс сурч боловсрох эрх нь зөрчигдсэн бүлэг юм.

Эмзэг бүлгийн хүүхдүүд Алслагдсан сум дүүрэг, хороодын нийгэм-эдийн засгийн статусын хувьд эмзэг байдалд байгаа амьжиргааны баталгаажих түвшнээс доогуур орлоготой өрхөд амьдарч буй хүүхдүүд

Үндэстний цөөнх бол тухайн улсад зонхилох байр суурь эзэлдэггүй бөгөөд тодорхой үндэстэн, угсаатан, шашин шүтлэг, эсвэл хэлний хувьд олонх хүн амаас ялгардаг хувь хүмүүс юм (UNCHR, Fact sheet no18, Minority rights) Үндэстний цөөнх гэдэг нь тухайн улсын хүн амын дийлэнхтэй харьцуулахад тооны хувьд цөөн бөгөөд хэл, арьсны өнгө, соёл иргэншлийнхээ хувьд ялгарах өөрсдийн өвөрмөц байдлыг хадгалах хүсэл эрмэлзэл бүхий тодорхой бүлэг хүмүүс юм (ХЭҮК, 2010).

Хөгжлийн бэрхшээлтэй хүүхэд гэдэгт бие махбод, оюун санаа, сэтгэл мэдрэл, мэдрэхүйн байнгын согог нь орчны бусад саадтай нийлсний улмаас бусдын адил нийгмийн амьдралд бүрэн дүүрэн, үр дүнтэй оролцох чадвар нь хязгаарлагдсан, 18 нас хүрээгүй хүн бүрийг (Хөгжлийн бэрхшээлтэй хүний эрхийн тухай. МУ-ын хууль. 4.1.1, Хүүхдийн эрхийн тухай конвенц)

ЛГБТИК + ЛГБТИК гэдэг нь бэлгийн цөөнхийг хэлэх олон улсын хэвшмэл нэр томъёоны товчлол юм.

“Л” гэдэг нь ижил хүйсийн бэлгийн чиг баримжаатай эмэгтэйчүүд буюу лесбиян, “Г” нь ижил хүйсийн бэлгийн чиг баримжаатай эрэгтэйчүүд буюу гей, “Б” нь аль аль хүйсийн хүмүүст чиглэсэн бэлгийн чиг баримжаатай бисексуал хүмүүс бол “Т” нь өөрийн хүйсийг төрсөн хүйсээсээ өөрөөр эсвэл эсрэгээр мэдэрч, мэдэрч буйгаараа хүйсээ илэрхийлж амьдардаг транс хүмүүсийг хэлдэг. “И” нь аль аль хүйсийн анхдагч болон хоёрдогч бэлгийн шинж чанарыг буюу хромосом, гонад болон нөхөн үржихүйн эрхтний хувьд эр, эм аль хүйст хамаарахыг нь шууд хэлэх боломжгүй хүмүүсийг интерсекс гэнэ. “К” нь бэлгийн чиг баримжаа болоод хүйсийн баримжаа, илэрхийллийн хувьд цөөнх хүмүүсийг нийтэд нь ЛГБТИ эсвэл Күйр гэдэг. Түүхийн хувьд энэхүү үг нь нэлээд сөрөг утга агуулдаг байсан ч энэ үгийг ЛГБТИ хүмүүс өөрийн болгож авч чадсан. Хэдийн тийм ч бүх ЛГБТИ хүмүүс энэ үгийг өөртөө хамаатуулан ашигладаггүй. Ихэвчлэн энэ нэр томъёог хүйс болон бэлгийн чиг баримжааг хоёрхон туйлт хэмээн үзэхийн эсрэг байдаг ЛГБТИ хүмүүс хэрэглэдэг. (ЛГБТ төв ТББ-аас “Бэлгийн цөөнхийн тухай түгээмэл асуугддаг асуултууд” гарын авлагыг авах боломжтой)

UIN.MN
СУДАЛГААНЫ САН

ҮЕ ТЭНГИЙН ДЭЭРЭЛХЭЛТЭЭС УРЬДЧИЛАН СЭРГИЙЛЭХ ЧИГЛЭЛЭЭР ДЭЛГЭРҮҮЛЖ СУДЛАХ БОЛОМЖТОЙ ЭХ СУРВАЛЖИЙН ЖАГСААЛТ

Монгол хэлээр

1. “Боловсролын хяналт мониторингийн дэлхийн тайлан 2020”, ЮНЕСКО
2. “Залуусын дундах хүчирхийллийн судалгаа”, Демокрейти залуусын төв ТББ, 2018 он
3. “Монгол улс дахь хүний эрхийн нөхцөл байдлын талаарх 16 дахь илтгэл”, ХЭҮК 2017 он
4. “Нийгмийн ялгаатай байдлыг сургалтын хөтөлбөр, сурах бичигт тусгах удирдамж” “Бүх нийт боловсролын төлөө!” Иргэний нийгмийн үндэсний эвсэл, 2017 он
5. “Оюутан залуусын дундах дарамт, дээрэлхэлтийн асуудал” судалгаа, “Өөрчлөлтийн салхи”, 2018 он
6. “Өсвөр үеийнхний дуу хоолой” судалгаа, Хүүхдийг ивээх сан, 2017 он
7. “Тэгш хамруулах, хүүхэд хамгааллын сайн туршлага”, “Бүх нийт боловсролын төлөө!” Иргэний нийгмийн үндэсний эвсэл, 2020 он
8. “Хүний эрхэд ээлтэй сургууль болох нь” (сургуулиудад зориулсан удирдамж), Эмнести Интернэшнл, 2012 он
9. “Сайн сургуулийг дэмжих аргачлал” гарын авлага, Боловсролын салбар дахь ил тод байдал, эгэх хариуцлага” төсөл, 2018 он
10. “Сургуулийн орчин дахь хүчирхийллийг арилгах нь” (багш нарт зориулсан гарын авлага), ЮНЕСКО, 2017 он
11. “Тодорхой бүлгийн хүүхдүүдэд боловсрол эзэмшихэд тулгардаг саад тотгорууд” (чанарын судалгааны тайлан), “Бүх нийт боловсролын төлөө!” Иргэний нийгмийн үндэсний эвсэл, 2020 он
12. “Үе тэнгийнхний дарамтыг өөр өнцгөөс харах нь: Та юу хийж чадах вэ? (нийгмийн ажилтан, сэтгэл зүйч, багш нарт зориулсан гарын авлага), Боловсролын Зөвлөгөө Мэдээллийн төв

Англи хэлээр

1. Anti-Bullying Procedures for Primary and Post-Primary Schools September 2013 copyright by Department of Education and Skills - (Action Plan on Bullying – Report of the Anti-Bullying Working Group to the Minister for Education and Skills)
2. International Bullying Prevention Association (IBPA) San Diego, CA, USA Conference Session Materials 2018
3. MINDSET The New Psychology of Success copyright 2006, 2008 by Carol S. Dweck, Ph.D.
4. The Bully, the Bullied, and the Bystander copyright 2003, 2008 by Barbara Coloroso

“БҮХ НИЙТ БОЛОВСРОЛЫН ТӨЛӨӨ!”

ИРГЭНИЙ НИЙГМИЙН ҮНДЭСНИЙ

ЭВСЛИЙН ТУНХАГ

Боловсрол нь хүн бүрийн өдөр тутмын амьдралд, насан турш нөлөөлөх үндсэн эрх, хүний хөгжлийн түлхүүр бөгөөд иргэн бүрт чанартай боловсрол олгох нь төрийн хүлээх гол үүрэг хариуцлага гэдэгт итгэн;

Өнөөгийн тогтолцоонд боловсролыг явцуу тодорхойлдог, хүн бүрийн ялгаатай байдлыг харгалздаггүй, ялгаварлан гадуурхдаг, хангалттай санхүүжилт олгодоггүй зэргээс шалтгаалан бодлого төлөвлөх, хэрэгжүүлэх үйл явцад цогц хандлага дутагдаж; боловсролын тогтолцооны үр өгөөж нь хувь хүний хүсэл тэмүүлэл, нийгмийн эрэлт хэрэгцээнээс асар зөрүүтэй байсаар ирсний улмаас үнэ цэнэтэй амьдарч, амьдралын чанараа дээшлүүлэх боломж олгохгүй байгаад сэтгэл зовнин;

Энэ нь эрх мэдлийн шударга бус бүтцийг бий болгож, тэгш бус байдлыг хадгалж үлдэх арга зам болж байгааг эсэргүүцэн;

Боловсролын чанар, хүртээмж, хариуцлагатай байдлын төлөө хүчээ нэгтгэн ажиллаж, энэ үйл явцад хувь хүн, иргэний нийгмийн байгууллага, бүлгүүдийг өргөнөөр татан оролцуулж, өргөн суурьтай, зохион байгуулалттай, хүчтэй хөдөлгөөн бий болгохыг чухалчлан;

Энэ үйл явцад нийгмийн бүх бүлэг, ялангуяа эрх мэдлийн цөөнхийн оролцоог хангахыг онцлон;

Иргэд, бүлгүүдийн мэдлэг, чадварыг хөгжүүлж, тулгарсан асуудлаа гаргаж ирэх, шийдлийг шаардах, хариуцлага тооцох чадавхтай болоход нь дэмжлэг үзүүлэхийг эрмэлзэн;

Боловсролын тогтолцоог хүний мэдэх, бүтээх, хүний ёсоор хамтран амьдарч, нэр төртэйгээр оршиход суралцахуйц, хувь хүний потенциал, чадвар, чадавхыг нээж, эерэг зан үйл, хандлагыг төлөвшүүлэхэд чиглэгдсэн, хүмүүнлэг, ардчилсан, хүн бүрийн эрхийг хангасан, тэгш хүртээмжтэй болгон өөрчлөхийг эрхэмлэн;

Хүүхэд, эцэг эх, багш, орон нутгийн бүлгүүд болон үндэсний, хэлний, соёлын, бэлгийн цөөнх, хөгжлийн бэрхшээлтэй хүүхдүүд, орлого багатай иргэд зэрэг дуу хоолойгоо хүргэж, шийдвэр гаргахад оролцож чадахгүй байгаа бүлгүүдийг эрх мэдэлжүүлэх зорилгоор боловсролын тогтолцоо, бодлогод хяналт шинжилгээ, үнэлгээ хийх чадавхыг бүрдүүлэх, нөлөөлөх ур чадвараа дээшлүүлэх шаардлагыг ухамсарлан;

Хүний эрх, жендэрийн тэгш эрх, үл ялгаварлан гадуурхах, хүчирхийллээс ангид, хүлээцтэй байх, нээлттэй, ил тод, хариуцлагатай байх зарчмыг баримтлан;

Монгол улсад боловсролын чанар, хүртээмжийг сайжруулах, төсвийг хянах, хариуцлага шаардах, бодлогод нөлөөлөх үндэсний кампанит ажил зохион байгуулах зорилгоор эвсэн нэгдсэнээ тунхаглаж байна.

2010 оны 9 сарын 3



UIH.MN
СЭДЭГ ААНЬ САН